

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ХАЯГЖУУЛАЛТЫН ТУХАЙ
(Шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гудамж, зам, талбай, газар, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хаягжуулалтын тухай хууль тогтоомж

2.1.Хаягжуулалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Авто замын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт /зүйл/

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
/хэсэг/

3.1.1."гудамж" гэж хот, суурин газрын эгнэсэн хашаа, барилга, байр, байшингийн хоорондох орон зайг; **/заалт/**

3.1.2."дэлгэрэнгүй хаяг" гэж хаягийн үндсэн болон нэмэлт бүрдлийн мэдээллийг агуулсан хаягийг;

3.1.3."зам" гэж Авто замын тухай хуулийн 4.1.1-т заасныг;

3.1.4."замын нэгж хэсэг" гэж замын нэр өгөхийн тулд тогтоосон эхлэл болон төгсгөлийн цэгийн хоорондох зайг хэрчимд хувааж, дугаарласныг;

3.1.5."замын нэр" гэж зам, гудамжны хэсэг тус бүрт өгсөн нэрийг хэлнэ;

3.1.6."талбай" гэж нийтийн эзэмшлийн тодорхой зааг бүхий талбар газрыг, гудамж, өргөн чөлөөтэй холбогдсон олон нийтийн зориулалттай тодорхой зааг бүхий орон зайг;

3.1.7."тэмдэгжүүлэх" гэж хаягийн тэмдэг, самбарыг стандартын дагуу үйлдвэрлэх, байршуулах үйл ажиллагааг;

3.1.8.'хаяг' гэж байршлыг тогтоох зорилгоор хаягийн объектын байршлыг хоёрдмол утгагүй илэрхийлэх мэдээллийг;

3.1.9."хаягжуулах" гэж гудамж, зам, талбай болон хаягийн объектыг нэрлэх, дугаарлах, өөрчлөх, хүчингүй болгох, хаягийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх, тэмдэгжүүлэх цогц үйл ажиллагааг;

3.1.10."хаягийн дугаар" гэж хаягийн объектын байршлыг тодорхойлох зорилгоор хаягийн мэдээллийн системээс олгосон үсэг, тоо, тэмдгийн иж бүрдлийг;

3.1.11."хаягийн зураг" гэж хаягжуулах, хөтлөх, мэдээлэл өгөх зорилгоор орон зайн өгөгдөл, мэдээлэлд суурилсан хаягийн мэдээллийг нэгтгэж боловсруулсан газрын зургийг

3.1.12."хаягийн мэдээллийн сан" гэж хаягийн орон зайн өгөгдөл мэдээллийн иж бүрдлийг;

3.1.13."хаягийн мэдээллийн систем" гэж хаягийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, хайх, илгээх, хүлээн авах, ашиглах болон аюулгүй байдлыг хангах зорилго бүхий программ хангамж, техник хангамж, мэдээллийн сан, бусад бүрэлдэхүүн хэсэг, тэдгээрийн иж бүрдлийг;

3.1.14."хаягийн объект" гэж өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн газар болон барилга, байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, хөшөө, соёл, дурсгал, нийтийн тээврийн хэрэгслийн буудал болон хаягжуулах, дугаарлах шаардлагатай бусад биет зүйлсийг;

3.1.15."хаягийн торлолын дугаар" гэж Монгол Улсын нутаг дэвсгэрийг торлосон хэлбэрээр арав арван метрийн хэмжээтэй шоонд хувааж тус бүрт олгосон дугаарыг;

3.1.16."хаягийн тэмдэг, самбар" гэж хаягийн объект болон зориулалтын тулгуур дээр байрлуулсан зураг, стандартаар тогтоосон бичвэр, мэдээллийг;

3.1.17."нэрэмжит нэр" гэж түүхэнд онцгой гавьяа байгуулсан хүн, байгууллага болон олон улсын хамтын ажиллагаанд зориулан өгсөн гудамж, зам, талбайг хүндэтгэлийн нэрээр нэрлэснийг.

4 дүгээр зүйл.Хаягжуулалтад баримтлах зарчим

4.1.Хаягжуулах үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1.хаягжуулах ажил нэгдсэн арга зүйтэй байх;

4.1.2.хаягжуулах үйл ажиллагаа нь орон зайн мэдээллийн системд суурилсан байх;

4.1.3.гудамжны эхлэл цэг нь хот суурины төвөөс эхлэлтэй байх;

4.1.4.гудамж, зам, талбай, нэгж талбарын орц гарц нь аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, түүнд нийцүүлэн боловсруулсан сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан байх;

4.1.5.хаягийн объектыг гудамж, зам, талбай болон газар зүйн нэр, хаягийн торлолын дугаарт харьяалуулсан байх;

4.1.6.гудамж, зам, талбай бүр оноосон нэртэй байх;

4.1.7.сум, дүүрэгт гудамж, зам, талбайн нэр давхардахгүй байх;

4.1.8.хаяг үнэн зөв, энгийн, ойлгомжтой, стандарттай байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХАЯГИЙН ОБЪЕКТ, ХАЯГИЙН БҮРДЭЛ, ХАЯГИЙН ТЭМДЭГ

5 дугаар зүйл.Хаягийн объект

5.1. Дараах газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг олгоно:

5.1.1.өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн газар болон барилга, байгууламж;

5.1.2.энэ хуулийн 5.1.1-д зааснаас бусад цэцэрлэгт хүрээлэн, хөшөө, соёл, дурсгал, нийтийн тээврийн хэрэгслийн буудал болон хаягжуулах, дугаарлах шаардлагатай гэж үзсэн объект.

6 дугаар зүйл.Хаягийн бүрдэл, бичвэр

6.1.Хаягийн бүрдэл нь үндсэн болон нэмэлт бүрдэлтэй байх бөгөөд үндсэн бүрдэл нь дараах мэдээллээс бүрдэнэ:

6.1.1.засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн нэр, баг, хорооны газар нутгийн зааг, түүнтэй холбоотой бусад мэдээлэл;

6.1.2.гудамж, зам, талбайн нэр, газар зүйн нэр,

6.1.3.газар, үл хөдлөх эд хөрөнгийн дугаар.

6.2.Хаягийн нэмэлт бүрдэл нь дараах мэдээллээс бүрдэнэ:

6.2.1.шуудангийн нэгдсэн код;

6.2.2.нэрэмжит гудамж, талбайн нэр;

6.2.3.хороолол, хотхоны нэр;

6.2.4.газар, үл хөдлөх эд хөрөнгийн нэр;

6.2.5.үл хөдлөх эд хөрөнгийн орц, гарц, давхрын болон хаалганы дугаар;

6.2.6.хаягийн торлолын дугаар;

6.2.7.бусад.

7 дугаар зүйл.Хаягийн тэмдэг, самбар

7.1.Хаягийн тэмдэг дараах төрөлтэй байна:

7.1.1.гудамж, зам;

7.1.2.газар, үл хөдлөх эд хөрөнгө.

7.2.Хаягийн самбар дараах мэдээллийн төрөлтэй байна:

7.2.1.нутаг дэвсгэрийн нэгжийн;

7.2.2.хороолол, хотхоны;

7.2.3.талбайн;

7.2.4.түүх, соёлын дурсгалт газрын;

7.2.5.объектын байрлал заасан;

7.2.6.нэрэмжит гудамж, талбайн.

7.3.Хаягийн тэмдэг, самбарын бичвэрт тавигдах шаардлага, тэмдэгжүүлэлтийг үндэсний стандартаар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХАЯГЖУУЛАХ АРГАЧЛАЛ

8 дугаар зүйл.Гудамж, зам, талбайг тодорхойлох, нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох

8.1.Гудамж, зам, талбай болон орц гарцыг орон зайн өгөгдөл, мэдээлэлд тулгуурлан зураглана.

8.2.Гудамж, замаас замын нэгж хэсгийг тодорхойлж нэр өгнө.

8.3.Замын нэгж хэсэгт газар зүйн нэр, түүх, соёлын баримтад үндэслэн нэр өгнө. Гадаад орны нэршил, гадаадын иргэн, гадаадын хуулийн этгээд болон монгол улсын хуулийн этгээдийн нэрийг хориглоно.

8.4.Замын нэгж хэсэг, талбайд нийтэд нь болон хэсэгчлэн нэрэмжит нэр олгож болно.

8.5.Замын нэгж хэсэг, талбайг нэрлэхдээ газар зүйн нэрийг үндэслэл болгож, олон нийтээс санал авсан, утга агуулгын хувьд уялдаатай, энгийн, ойлгомжтой, хялбар үгээр нэрлэнэ.

8.6.Гудамж, зам, талбайг тодорхойлох болон нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох үйл ажиллагааг энэ хуулийн 12.2.2-д заасан журмаар зохицуулна.

8.7.Гудамж, талбайн нэрэмжит нэрийг үндсэн хаягийн бүрдэлд тусгахгүй, хаягийн самбар дээр бичиж болно.

9 дүгээр зүйл.Газар, үл хөдлөх эд хөрөнгийг дугаарлах

9.1.Энэ хуулийн 5.1-д заасан газар, үл хөдлөх эд хөрөнгө нь хаягийн дугаартай байна.

9.2.Гудамж, замын нэгж хэсгийн хэрчмийн дугаарыг замын зүүн талд байрлах объектыг сондгой тоогоор, баруун талд байрлах объектыг тэгш тоогоор тус тус дугаарлана.

9.3.Энэ хуулийн 8.2-т заасныг тодорхойлох боломжгүй тохиолдолд газар зүйн нэрийг үндэслэн хаягийн торлолыг дугаарт ашиглана.

9.4.Барилга, байгууламжийг дугаарлахдаа нэгж талбарын хаягийн дугаарын ард “/” ташуу зураасан тэмдэглэгээ тавьж, түүний ард дугаарыг бичнэ.

9.5.Энэ хуулийн 4.1.4-т заасан төлөвлөлтийн шатны нэгж талбарын хаягийн дугаарыг хаягийн мэдээллийн системээс олгоно.

9.6.Газар, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах үйл ажиллагааг энэ хуулийн 12.2.2-д заасан журмаар зохицуулна.

9.7.Дараах газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг олгохгүй:

9.7.1.өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүсээгүй газар, түүн дээр баригдсан инженерийн барилга, байгууламж;

9.7.2.цэвэр, бохир ус, дулаан, хий, цахилгаан, эрчим хүч, харилцаа холбооны дамжуулах, түгээх инженерийн шугам сүлжээ;

9.7.3.түр хугацаагаар ашиглагдах барилга байгууламж.

10 дугаар зүйл.Хаягжуулах дараалал

10.1.Хаягжуулах үйл ажиллагааг дараах дарааллаар хийж гүйцэтгэнэ:

10.1.1.гудамж, зам, талбай, орц, гарцын мэдээллийг агуулсан хаягийн зургийг бэлтгэх;

10.1.2.гудамж, зам, талбайн нэрийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулах;

10.1.3.хаягийн зургийг газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн систем болон хаягийн мэдээллийн системд бүртгэх;

10.1.4.хаягийн тэмдгийг байршуулах.

11 дүгээр зүйл.Хаягийн зураг бэлтгэх

11.1.Хаягийн зургийг орон зайн мэдээлэлд суурилан зохионо.

11.2.Хөшөө, соёл, түүхэн дурсгалт газрын нэрийг батлагдсан нэрээр нь хаягийн зурагт тусгана.

11.3.Аж ахуйн нэгж, аялал жуулчлалын байгууламжийн нэрийг тухайн эзэмшигч нь өгөх бөгөөд Монгол хэлний тухай хуулийн 6.1-д заасан төрийн албан ёсны хэлээр бичиж хаягийн зурагт тусгана.

11.4.Хаягийн зурагт батлагдсан нэр болон үл хөдлөх эд хөрөнгийн дугаар, хаягийн объектыг бүрэн тусгана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ХАЯГЖУУЛАЛТЫН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ,
ЧИГ ҮҮРЭГ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

12 дугаар зүйл.Хаягжуулалтын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг

12.1.Улсын Их Хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.хаягжуулалтын талаар төрийн бодлого тодорхойлох;

12.1.2.хаягжуулалтын үйл ажиллагааны санхүүжилтийг батлах.

12.2.Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.2.1.хаягжуулалтын талаар төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

12.2.2.гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг батлах;

12.2.3.хаягжуулалтын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх.

12.3.Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.3.1.хаягжуулалтын талаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

12.3.2.улсын хэмжээнд хаягжуулах үйл ажиллагаанд мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангаж, сургалтыг зохион байгуулах;

12.3.3.хаягжуулалтын стандарт, журам боловсруулах, мөрдүүлэх;

12.3.4.энэ хуулийн 5.1.2-д заасан хаягийн объектыг хаягжуулах, нэрлэх, нэрэмжит болгох, дугаарлах шаардлагатай нэмэлт жагсаалт батлах;

12.3.5.хаягийн мэдээллийн системийг улсын хэмжээнд хөтөлж, нэгдсэн удирдлага, хяналт, зохион байгуулалтаар хангах;

12.3.6.хаягийн торлол үүсгэх, дугаарлах;

12.3.7.хаягийн мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах, ашиглах, түгээх, аюулгүй байдлыг хангах;

12.3.8.хаягийн нэрийн санд нэр бүрдүүлэх, баяжуулах, ашиглах аргачлал, журам боловсруулж батлах.

12.4.Аймаг, нийслэлийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.4.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд хаягжуулах ажлыг хэрэгжүүлэх.

12.5.Төрийн захиргааны бусад байгууллага хаягжуулалтын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.5.1.хаягжуулалтын тухай хууль тогтоомжийн биелэлтийг харьяалсан салбартаа зохион байгуулах;

12.5.2.соёлын болон түүхэн дурсгалт газар, байгалийн өвөрмөц тогтоц бүхий газрыг аялал жуулчлалын зориулалтаар нэгдсэн бодлогоор хаягжуулахыг соёл, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулах;

12.5.3.боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь батлагдсан хаягийн хэрэглээ, ашиглалтын талаар сургалтын хөтөлбөрт тусгах;

12.5.4.шуудангийн нэгдсэн кодын бүсийг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн 4.1.1-д заасан нэгжид хамааруулан тогтоож Шуудангийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Шуудангийн

тухай хуулийн 7.1.4-д заасан шуудангийн нэгдсэн кодыг хаягийн мэдээллийн санд оруулах.

12.6.Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хаягжуулалтын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.6.1.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Авто замын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15.1.1-15.1.2 дахь заалтаас бусад гудамж, замын нэрийг батлана;

12.6.2.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 12.6.1 -д заасан эрхийг харьяа сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд эрхийг шилжүүлж болно;

12.6.3.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, зам, талбайг нэрэмжит болгох, өөрчлөх, шийдвэр гаргах.

12.7.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга, хаягжуулалтын талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.7.1.хаягжуулалтын талаар Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.12-д заасан болон бусад төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

12.7.2.аймаг, нийслэлийн Засаг дарга сум, баг, дүүрэг, хорооны гудамж, зам, талбайг хаягжуулах үйл ажиллагаанд хяналт тавих;

12.7.3.сум, дүүргийн Засаг дарга хаягжуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;

12.7.4.гудамж, зам, талбайд нэр өгөх, өөрчлөх, хүчингүй болгосон шийдвэрийг тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, сумын газрын даамалд ажлын тав хоногийн дотор хүргүүлж, хаягийн мэдээллийн санд бүртгэх;

12.7.5.сум, дүүргийн нутаг дэвсгэр дэх гудамж, зам, талбай, цэцэрлэгт хүрээлэн, нийтийн тээврийн хэрэгслийн буудал, хөшөөний хаяг, Засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн хил, баг, хорооны газар нутгийн заагийн мэдээлэл бүхий хаягийн самбарыг байршуулж, хаягжуулах үйл ажиллагааг тухайн шатны Засаг дарга хариуцан зохион байгуулах;

12.7.6.хаягжуулах үйл ажиллагааны тайланг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

12.7.7.орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх хаягжуулалтын ажлыг төлөвлөх, ажлын даалгавар, техникийн төслийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар хянуулах, хамтран батлах;

12.7.8.тэмдэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих;

12.7.9.хаягийн тэмдгийн бүрэн бүтэн байдалд сум, дүүргийн Засаг дарга хяналт тавих;

12.7.10.гудамж, зам, талбайг нэрэмжит болгохдоо олон нийтээс санал авч, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлүүлэх.

12.8.Сумын газрын даамал, дүүргийн газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг:

12.8.1.сум, дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлтэй уялдуулж гудамж, зам, талбайн нэр, орц, гарцыг төлөвлөх;

12.8.2.хаяг олгох үйл ажиллагааг хаягийн мэдээллийн системээр эрхлэн явуулах;

12.8.3.иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан гудамж, зам, талбайн нэрийг хаягийн мэдээллийн санд бүртгэх, хаягийн нэрийн санг хөтлөх.

12.9.Хүн, хуулийн этгээдийн чиг үүрэг:

12.9.1.гамшиг ослын үед аюулгүй байдлыг хангах зорилгоор хаягийн тэмдгийг стандартын дагуу байрлуулах, бүрэн бүтэн байдлыг хариуцах;

12.9.2.Авто замын тухай хуулийн 17.2, 17.3, 17.4-т заасан авто зам эзэмшигч нь шинээр байгуулах болон өөрчлөх авто замын мэдээллийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлэх;

12.9.3.аялал жуулчлалын үйлчилгээний байгууламжийг эзэмшигч хүн, хуулийн этгээд нь хаягийг тэмдэгжүүлэх;

12.9.4.стандартын шаардлага хангаагүй хаягийн тэмдэг, самбар ашиглахыг хориглох.

ТАВДУГААР БҮЛЭГ ХАЯГИЙН МЭДЭЭЛЛИЙН САН, СИСТЕМ

13 дугаар зүйл.Хаягийн мэдээллийн сан

13.1.Хаягийн мэдээллийн сан дараах мэдээллээс бүрдэнэ:

13.1.1.газар зүйн нэр, байршил;

13.1.2.засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн нэр, хил, зааг;

13.1.3.шуудангийн нэгдсэн код, бүсийн зааг;

13.1.4.хотхон, хорооллын нэр, зааг, түүнтэй холбоотой бусад мэдээлэл;

13.1.5.гудамж, зам, талбайн нэр, төрөл, эхлэл, төгсгөл, чиглэл, эгнээ, төвийн утга, уулзвар, объектод холбогдох цэгийн байршил, түүнтэй холбоотой бусад мэдээлэл;

13.1.6.газар, үл хөдлөх эд хөрөнгийн байршлын хаяг;

13.1.7.давхрын болон хаалганы дугаар;

13.1.8.хаягийн тэмдэг, самбарын мэдээлэл;

13.1.9.хаягийн нэрийн сан;

13.1.10.хаягийн торлолын дугаар;

13.1.11.бусад.

13.2.Хаягийн нэрийн санг газар зүйн нэр, түүх, соёлын баримтад үндэслэн бүрдүүлнэ.

13.3.Хаягийн мэдээллийг хаягийн мэдээллийн системээс хэвлэмэл болон тоон хэлбэрээр ашиглаж болно.

13.4.Улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангуулах зориулалттай тусгай объектын хаягийн бүрдэл мэдээллийг хаягийн зурагт тусгах, нийтэд түгээхийг хориглоно.

14 дүгээр зүйл.Хаягийн мэдээллийн систем

14.1.Хаягийн мэдээллийн систем нь төрийн мэдээллийн бусад сантай мэдээлэл солилцох боломжтой байх бөгөөд төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад дундын мэдээллийн сан үүсгэн ажиллуулна.

14.2.Хаягийн мэдээллийн системийг улс, аймаг, сум, нийслэл, дүүргийн хэмжээнд тогтмол хөтлөн явуулж, хаягийн бүртгэл, мэдээлэл цуглуулах, өөрчлөх, баталгаажуулах, хаягийн бүртгэл, мэдээллийг нийтэд хүргэх, холбогдох төрийн байгууллагатай мэдээлэл солилцох хэлбэрээр ашиглана.

14.3.Хаягжуулах болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг зөвхөн хаягийн мэдээллийн системээр дамжуулан зохион байгуулна.

14.4.Хаягийн мэдээллийн систем нь дараах шаардлагыг хангасан байна:

14.4.1.улсын хэмжээнд төлөвлөлт, бүртгэлийн шатнаас эхлэн энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан хаягийн объектод системээс хаяг олгодог байх;

14.4.2.энэ хуулийн 5.1.1-д заасны дагуу газрын эрх үүссэн, үл хөдлөх эд хөрөнгийг улсын комисс хүлээн авсны дараа хаягийн мэдээллийн системээр дамжуулан кадастрын мэдээллийн системд хаягийг бүртгэх;

14.4.3.иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон төрийн байгууллагууд хаягийн орон зайн болон орон зайн бус мэдээллийг ашиглах боломжтой байх;

14.4.4.хаягийн орон зайн мэдээлэл нь замчлалын шаардлага хангасан байх.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

15 дугаар зүйл.Хаягжуулалтын үйл ажиллагааны санхүүжилт

15.1.Улсын болон орон нутгийн төсвөөс дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ:

15.1.1.гудамж, зам, талбай болон энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан хаягийн объектыг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар хаягжуулах;

15.1.2.хаягийн мэдээллийн системийн ашиглалт, хөгжүүлэлт, хамгаалалт, албан хаагчдыг сургах;

15.1.3.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэр, хил, зааг, өөрчлөх;

15.1.4.нэрэмжит болгосон гудамж, зам, талбайг хаягжуулах.

15.2.Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч дараах зардлыг хариуцна:

15.2.1.хаягийн тэмдэг байрлуулах, түүний засвар үйлчилгээ;

15.2.2.нэгдсэн байдлаар хаягжуулсны дараа шинээр өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн тохиолдолд хаягжуулахтай холбоотой зардал.

15.3.Бусад байгууллага, санал гаргасан этгээд дараах зардлыг хариуцна:

15.3.1.хөшөө, соёл, дурсгал, аялал жуулчлалын байгууламжийг хаягжуулах;

15.3.2.нэрэмжит болгосон гудамж, зам, талбайг хаягжуулах.

15.4.Энэ хуульд заасан хаягийн тэмдэг, самбарыг гэмтээсэн, устгасан бол буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлж, сэргээн байршуулна.

16 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

16.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

17 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

17.1.Энэ хуулийг 202.... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ХАЯГЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улсын Их Хурлаас Хаягжуулалтын тухай хуулийг 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр 5 зүйл, 15 хэсэг, 22 заалттай баталсан бөгөөд гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой байдаг.

Хаягжуулалтын тухай хуульд өнгөрсөн 12 жилийн хугацаанд бусад холбогдох хууль шинээр болон шинэчлэн боловсруулагдсантай холбоотой 2 удаа өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор баталсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам”, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурлын Тэргүүлэгчид гудамж, талбайд нэр өгөх эрхийг хэрэгжүүлэхээр заасан бөгөөд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэл Улаанбаатар хотын гудамж, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, барилга, байгууламжид дугаар олгох журам” болон “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага MNS5283:2022”, “Хаягийн бичвэрт тавих шаардлага MNS6775:2019” зэрэг стандартаар тус тус хаягжуулах үйл ажиллагааг зохицуулсаар ирсэн.

Хаягжуулалтын тухай хуультай болсноор тодорхой хэмжээнд эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч хуулийн зохицуулалт хэт ерөнхий, тухайн хуулийн зохицуулалтын талаас илүү хувийг зарчим, тунхгийн шинжтэй заалтууд эзэлсэн, хаягжуулалттай холбоотой нэр томъёо, нэгдсэн аргачлал, стандарт зэрэг суурь асуудлыг бүрэн зохицуулж өгөөгүй, хуулиар зохицуулах шаардлагатай үндсэн харилцааг журам, стандартаар зохицуулахаар заасан, түүнчлэн журмаар зохицуулсан хаягжуулах аргачлал нь олон улсын хаягжуулалтын аргачлал, стандартаас хэт зөрүүтэй байгаа зэргээс шалтгаалж Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтын 1.3.4-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллагын нэр хаягийг монгол бичиг, кирилл бичгээр бичих асуудлыг журамлаж, стандарт мөрдүүлэн нийгмийн соёлыг дээшлүүлнэ.” гэж, 5.3.8-д “Газар зүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжуулалтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлнэ.” гэж, 9.2.40-д “Гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж бүрэн камержуулан, ард иргэдийн аюулгүй байдлыг хангаж, гудамж, талбайн нэр, байшин барилгын хаягийн нэгдсэн стандарт хангуулж, хотын соёлыг нэмэгдүүлнэ.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.6.2-т “Хаягжилтын нэгдсэн системийг Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.3-т “Хаягийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.2.2-т “Төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг дээшлүүлж, иргэдэд түргэн шуурхай, хялбар үйлчилгээ үзүүлэх цахим төрийн тогтолцоонд шилжинэ.” гэж, 4.3.1.5-д “Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэл, газрын

хэвлийн баялаг болон газар дээрх баялгийн бүртгэлийг блокчейн технологийг ашиглан гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.” гэж, 4.4.4.10-т “Эрсдэлийн мэдээлэлд суурилсан гамшгаас хамгаалах удирдлага, үйл ажиллагааг оновчтой хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий гамшгийн зураглал, байгаль орчин, уур амьсгалын эрсдэлийн мэдээллийн сан, гамшгийн эрсдэл хуваалцах тогтолцоог хөгжүүлж, олон нийтэд нээлттэй болгоно.” гэж тус тус заасан.

“Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хаягжуулалттай холбоотой практик дээр үүссэн нөхцөл байдлыг эрх зүйн хүрээнд тодорхой болгож, нарийвчлан оновчтой зохицуулах, төрийн зүгээс хаяг, хаягийн өгөгдлийг олон улсын жишиг болон өөрийн орны практик шаардлагад нийцүүлэх, нэг стандартад оруулах, нээлттэй, хүртээмжтэй болгох, хаягийн мэдээллийн нэгдсэн системийн удирдлага, зохион байгуулалтыг бий болгох, хаягжуулалтын зарчим, хаягийн объект, хаягийн дугаар, хаягийн мэдээллийн сан, хаягийн бүрдэл, үл хөдлөх эд хөрөнгийг дугаарлах, шуудангийн нэгдсэн кодыг оноохтой холбоотой объектыг хаягжуулах аргачлал, шинээр хаяг олгох, өөрчлөхтэй холбоотой хаягжуулах үйл ажиллагаа, оролцогч төрийн байгууллага болон үйл ажиллагааны санхүүжилт, хориглох үйл ажиллагаа, хүчин төгөлдөр болох хугацаа зэргийг тусган, боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

Нийгмийн тасралтгүй хэрэгцээ, технологийн өндөр хөгжил нь (орон зайн өгөгдөл, газар зүйн мэдээллийн систем, интернэтийн хурд, хүртээмж (5G), веб болон гар утасны апп) хаягжуулалт, хаягийн мэдээллийн хэрэглээг улам бүр нэмэгдүүлж, нийгэм, эдийн засгийн хүрээнд хаягжуулалт, хаягийн систем нь иргэнд чиглэсэн олон төрлийн үүргийг гүйцэтгэж байгаа бөгөөд энэ харилцааг дээр дурдсан хууль, журмаар зохицуулж чадахгүй болж, хаягжуулалтын ажлыг зохион байгуулахад дараах хүндрэл үүсэж байна. Үүнд:

1.Хаягийн мэдээллийн цахим систем, түүний өгөгдлийг зохион байгуулах, удирдах зохицуулахад эрх бүхий байгууллагуудын хооронд ойлголтын зөрүү үүсэх, уялдаа холбоо алдагдах;

2.Хаягжуулах ажлыг ямар аргачлал, арга зүйгээр зохион байгуулах нь тодорхойгүй байх;

3.Хаягжуулалтад оролцогч талуудын эрх, үүргийг хуульд заагаагүйгээс аймаг, нийслэл болон сумын төв, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгонд гудамж (зам, талбай, хороолол, хотхон)-ны нэр, дугаар, хашаа, барилга байгууламжийн нэр, эсхүл дугаар, хаалганы дугаарыг ямар субъект хариуцан олгох, өөрчлөх, хадгалах, уялдуулах зэрэг нь тодорхой биш байх;

4.Бүсчлэлийн код болон хаягийн бүсийг ашиглах тухай зохицуулалт байхгүй;

5.Хаягийн мэдээллийн санг практик шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, хүртээмжтэй болгох, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх талаар эрх зүйн орчин дутмаг;

6.Монгол Улс, тэр дундаа нийслэл Улаанбаатар хотод хаягийн тэмдэг, тэмдэглэгээ хангалтгүй, шуудангийн хайрцаг, түүний хэрэглээг бий болгох талаар бодлогын зохицуулалтууд байхгүй;

7.Хаягтай холбоотой үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалтгүй зэрэг болно.

Хуулийн төсөл батлагдсанаар газар зүйн мэдээлэлд суурилсан хаягийн мэдээллийн нэгдсэн систем бий болгох, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг үнэн зөв, энгийн ойлгомжтой, дахин давхцахгүй байдлаар хаягжуулах талаар төрөөс авч хэрэгжүүлж буй бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж иргэдийн эзэмшилд байгаа үл хөдлөх

хөрөнгийг бүртгэж эдийн засгийн эргэлтэд оруулах, шуудан, цахим худалдааны болон төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх нөхцөлийг сайжруулах замаар нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

Улсын хэмжээний хаягийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож, хаягийн нэгдсэн санг практик шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, хүртээмжтэй, ил тод, нээлттэй болгосноор хүн, хуулийн этгээд газар, үл хөдлөх хөрөнгийн мэдээллийг авах, үйл ажиллагаандаа ашиглах хууль, эрх зүйн болон бизнесийн таатай орчныг бүрдүүлнэ.

Газар нутаг, суурин газарт байгаа гудамж, зам, талбай, үйлдвэр, аж ахуйн нэгж, хотхон, төлөвлөлтгүй суурьшсан хэсэг, үл хөдлөх эд хөрөнгөд нэр дугаар төлөвлөж хаягийн төслийн байр зүйн сэдэвчилсэн зураг үйлдэх, төлөвлөлтийн шатанд хаяг олгох асуудлын эрх зүйн зохицуулалт тодорхой болно.

Хаягийн мэдээллийн нэгдсэн системийн удирдлага, зохион байгуулалтын эрх, үүргийг тодорхойлсноор төрийн байгууллагуудын бусад мэдээллийн сантай уялдуулж, төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулж, иргэний болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн статистик тоон мэдээ үнэн зөв, бодитой болно.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа хөгжингүй орны хууль эрх зүйн орчныг судлахаас гадна Бүгд Найрамдах Солонгос Улсын “Замын нэр хаягийн тухай хууль”-ийн албан ёсны мэргэжлийн орчуулгыг ашигласан. Түүнчлэн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомжийг судалж, холбогдох зүйл заалтуудыг уялдуулах, хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах шаардлагатай заалтуудыг нийцүүлэн тусгасан.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 60 дугаар захирамж, Барилга, хот байгуулалтын Сайдын 2021 оны 152, 2022 оны 141 дүгээр тушаал, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2025 оны 144 дүгээр тушаалаар тус тус Ажлын хэсэг байгуулагдаж, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу Хаягжуулалтын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааг хийж, үзэл баримтлалыг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд болон Хууль, зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталсан.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Бүгд Найрамдах Солонгос Улсын Дотоод хэрэг, аюулгүй байдлын яамны дэд сайд Ким Мин Жэ-тэй Монгол Улсын хаягийн мэдээллийн системийг шинэчлэх, шинэ технологийг нэвтрүүлэх, боловсон хүчнийг сургаж, хөгжүүлэхэд хамтран ажиллах, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Сөүл хотод хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Бүгд Найрамдах Солонгос Улсын Дотоод хэрэг, аюулгүй байдлын сайд И Сан Мин-тэй Засгийн газрын үйл ажиллагааг цахимжуулж бүтээмжийг нэмэгдүүлэх, төрийн албаны реформ хийхэд зөвлөх үйлчилгээ авах чиглэлээр 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Улаанбаатар хотод хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Бүгд Найрамдах Солонгос Улсын Газар, Геоматик (LX)-ийн Корпорацын ерөнхийлөгч Эо Мён Со-той Монгол Улсын Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, хаягийн нэгдсэн системийг шинэчлэх, шинэ технологийг нэвтрүүлэх, боловсон хүчнийг сургаж, хөгжүүлэхэд хамтран ажиллах, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2024 оны 11 дүгээр сарын 11 дүгээр сарын 06-ны өдөр Сөүл хотод

хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Бүгд Найрамдах Солонгос Улсын Дотоод хэрэг, аюулгүй байдлын яамны дэд сайд Ким Мин Жэ-тэй Монгол Улсын хаягийн мэдээллийн системийг шинэчлэх, шинэ технологийг нэвтрүүлэх, боловсон хүчнийг сургаж, хөгжүүлэхэд хамтран ажиллах, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Сөүл хотод хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан.

Хаягжуулалттай холбоотой практик дээр үүссэн нөхцөл байдлыг эрх зүйн хүрээнд тодорхой болгож, нарийвчлан оновчтой зохицуулах, төрийн зүгээс хаяг, хаягийн өгөгдлийг олон улсын жишиг болон өөрийн орны практик шаардлагад нийцүүлэх, нэг стандартад оруулах, нээлттэй, хүртээмжтэй болгох, хаягийн мэдээллийн нэгдсэн системийн удирдлага, зохион байгуулалтыг бий болгох шаардлагаар Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулсан.

Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах байгууллагуудаас санал авсан. Үүнд:

1. Хууль зүй, дотоод хэргийн яам;
2. Зам тээврийн яам;
3. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам;
4. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам;
5. Улсын бүртгэлийн ерөнхий газар;
6. Стандарт, хэмжил зүйн газар;
7. 21 аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар;
8. Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газар;
9. Нийслэлийн газар зохион байгуулалтын алба.

Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын дагуу Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлж, 21 аймаг, 330 сумын хэмжээнд 37,401 гудамж, 222,195 зам, 258,650 газар, усны нэр, 628,436 орц, гарцыг мэдээллийн санд бүртгэн оруулж, 202,159 барилга, 767,519 нэгж талбар, өвөлжөө, хаваржаа, газар тариалангийн газрын нэгж талбарт хаяг олгогдсон бөгөөд тухайн хаягийг ашиглан газар, үл хөдлөх эд хөрөнгийн тэмдэгжүүлэлтийн ажлыг 206 суманд хийсэн байдаг. Нийслэл, үлдсэн 124 суманд хаягийн тэмдэгжүүлэлтийн ажил хийгдээгүй байгаа нь эрх зүйн орчин дутмаг байгаагаас хаягжуулалт хийх, улсын хэмжээнд үйл ажиллагаанд ашиглах, бусад байгууллагатай харилцан мэдээлэл солилцон хаягийн нэгдсэн бүртгэлийг бий болгоход хүндрэлтэй асуудлууд тулгарч байна.

Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн мэдээллийн систем”-ийн ашиглалтыг сайжруулах зорилгоор төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбож, өгөгдөл мэдээлэл солилцох “Дундын мэдээллийн сан”-г 2025 оны 04 дүгээр сард шинээр хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлсэн нь төрийн байгууллагууд дундын мэдээллийн сангаар дамжуулан газрын харилцаатай холбоотой өгөгдөл мэдээлэл болон хаягийн нэгдсэн мэдээллийг солилцох боломжийг бүрдүүлээд байна.

“Монгол Улсын хаягийн мэдээллийн системийг шинэчлэх” төслийг Бүгд Найрамдах Солонгос Улсын КОЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэгтэйгээр 2026 оноос эхлэн хэрэгжүүлнэ.

Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, хуулийн төсөлд тусгасан зарчмын шинжтэй зохицуулалтууд:

Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн ерөнхий агуулгыг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хэрэгцээ, шаардлагын

урьдчилсан тандан судалгаанд үндэслэн уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд заасан 6 (зургаа) агуулгын хүрээнд боловсруулсан.

Нэгдүгээр бүлэгт (Нийтлэг үндэслэл) хуулийн зорилт, хаягжуулалтын тухай хууль тогтоомж, нэр томъёоны тодорхойлолт, хаягжуулалтад баримтлах зарчимтай холбоотой зохицуулалтыг;

Хоёрдугаар бүлэгт (Хаягийн объект, хаягийн бүрдэл, хаягийн тэмдэг) хаягийн объект, хаягийн бүрдэл, бичвэр, хаягийн тэмдэг, хаягийн самбартай холбоотой харилцааг;

Гуравдугаар бүлэгт (Хаягжуулах аргачлал) хаягжуулах дараалал, хаягийн зураг бэлтгэх, гудамж, замыг тодорхойлох, нэрлэх, үл хөдлөх эд хөрөнгийг дугаарлах, шуудангийн нэгдсэн кодтой холбоотой харилцааг;

Дөрөвдүгээр бүлэгт (Хаягжуулах ажлыг зохион байгуулах) хаягжуулах ажлыг зохион байгуулахтай холбоотой зохицуулалтыг;

Тавдугаар бүлэгт (Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем) хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг эрхлэхтэй холбоотой зохицуулалтыг;

Зургаадугаар бүлэгт (Бусад зүйл) хаягжуулалтын үйл ажиллагааны санхүүжилт, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалтыг тус тус тусгасан.

Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Авто замын тухай хууль, Хот байгуулалтын тухай хуульд нийцэх бөгөөд 6 бүлэг, 17 зүйлтэй, хуулийн төсөлтэй холбогдуулан Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Хаягжуулалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

---oOo---

БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	БАТЛАВ. ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	БАТЛАВ. ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	БАТЛАВ. ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
С.БЯМБАЦОГТ	Э.БАТШУГАР	Э.БАТ-АМГАЛАН	Л.МӨНХБААТАР

ХАЯГЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, практик шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтын 1.3.4-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллагын нэр хаягийг монгол бичиг, кирилл бичгээр бичих асуудлыг журамлаж, стандарт мөрдүүлэн нийгмийн соёлыг дээшлүүлнэ.” гэж, 5.3.8-д “Газар зүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжуулалтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлнэ.” гэж, 9.2.40-д “Гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж бүрэн камержуулан, ард иргэдийн аюулгүй байдлыг хангаж, гудамж, талбайн нэр, байшин барилгын хаягийн нэгдсэн стандарт хангуулж, хотын соёлыг нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.6.2-т “Хаягжилтын нэгдсэн системийг Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулна.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.3-т “Хаягийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.2.2-т “Төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмжийг дээшлүүлж, иргэдэд түргэн шуурхай, хялбар үйлчилгээ үзүүлэх цахим төрийн тогтолцоонд шилжинэ.” гэж, 4.3.1.5-д “Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэл, газрын хэвлийн баялаг болон газар дээрх баялгийн бүртгэлийг блокчейн технологийг ашиглан гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.” гэж, 4.4.4.10-т “Эрсдэлийн мэдээлэлд суурилсан гамшгаас хамгаалах удирдлага, үйл ажиллагааг оновчтой хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий гамшгийн зураглал, байгаль орчин, уур амьсгалын эрсдэлийн мэдээллийн сан, гамшгийн эрсдэл хуваалцах тогтолцоог хөгжүүлж, олон нийтэд нээлттэй болгоно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 181

дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хаягжуулалттай холбоотой практик дээр үүссэн нөхцөл байдлыг эрх зүйн хүрээнд тодорхой болгож, нарийвчлан оновчтой зохицуулах, төрийн зүгээс хаяг, хаягийн өгөгдлийг олон улсын жишиг болон өөрийн орны практик шаардлагад нийцүүлэх, нэг стандартад оруулах, нээлттэй, хүртээмжтэй болгох, хаягийн мэдээллийн нэгдсэн системийн удирдлага, зохион байгуулалтыг бий болгох, хаягжуулалтын зарчим, хаягийн объект, хаягийн дугаар, хаягийн мэдээллийн сан, хаягийн бүрдэл, үл хөдлөх эд хөрөнгийг дугаарлах, шуудангийн нэгдсэн кодыг оноохтой холбоотой объектыг хаягжуулах аргачлал, шинээр хаяг олгох, өөрчлөхтэй холбоотой хаягжуулах үйл ажиллагаа, оролцогч төрийн байгууллага болон үйл ажиллагааны санхүүжилт, хориглох үйл ажиллагаа, хүчин төгөлдөр болох хугацаа зэргийг тусган, боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

1.2.Практик шаардлага

Монгол Улсад хаягтай холбогдсон харилцааг 2013 онд баталсан Хаягжуулалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор баталсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам”, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэл Улаанбаатар хотын гудамж, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, барилга, байгууламжид дугаар олгох журам”-аар болон “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага MNS5283:2022”, “Хаягийн бичвэрт тавих шаардлага MNS6775:2019” зэрэг стандартаар тус тус зохицуулж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь гудамж, талбайд нэр өгөх эрхийг хэрэгжүүлэхээр заасан бөгөөд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэл Улаанбаатар хотын гудамж, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, барилга, байгууламжид дугаар олгох журам”-ын дагуу нийслэлийн хэмжээнд гудамж, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, барилга байгууламжид дугаар олгох, өөрчлөх үйл ажиллагаанд мөрдөж байна.

Хаягжуулалтын тухай хууль нь 5 зүйл, 15 хэсэг, 22 заалттай байгаа бөгөөд өнгөрсөн 12 жилийн хугацаанд 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан нь бусад хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж оруулсан өөрчлөлт байдаг байна.

Хаягжуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд Хаягжуулалтын тухай хуультай болсноор тодорхой хэмжээнд эрх зүйн орчин бүрдсэн ч хуулийн зохицуулалт хэт ерөнхий, тухайн хуулийн зохицуулалтын талаас илүү хувийг зарчим, тунхгийн шинжтэй заалтууд эзэлсэн, хаягжуулалттай холбоотой нэр томъёо, нэгдсэн аргачлал, стандарт зэрэг суурь асуудлыг бүрэн зохицуулж өгөөгүй, хуулиар зохицуулах шаардлагатай үндсэн харилцааг журам, стандартаар зохицуулахаар заасан, түүнчлэн журмаар зохицуулсан хаягжуулах аргачлал нь олон улсын хаягжуулалтын аргачлал, стандартаас хэт зөрүүтэй байна гэж дүгнэсэн байх бөгөөд уг үнэлгээнд үндэслэн Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах дараах практик хэрэгцээ, шаардлага байна. Үүнд:

1.2.1.Хаягийн объект, хаягийн бүрдэл, стандартын талаар:

Хаягжуулалтын тухай хуульд хаягжуулах объектыг гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө гэж тодорхойлсон боловч “гудамж”, “зам”, “талбай”, “өргөн чөлөө”, “туслах зам”, “мухар зам” гэж юуг ойлгох талаар нэр томъёог тодорхойлж өгөөгүй нь хуулийг хэрэгжүүлэхэд ойлгомжгүй байдал үүсгэж байна. Тухайлбал, хаягжуулалтын суурь нь зам бөгөөд зам нь өөрөө төрөлтэй, түүний нэг төрөл нь гудамж гэж ойлгож, хэрэглэж байгаа практик олон улсад байдаг. Мөн “талбай” гэдэгт ногоон байгууламж, авто зогсоол, цэцэрлэгт хүрээлэн зэрэг ямар объект орох талаар тодорхой зааж өгөөгүй байна.

Түүнчлэн хуульд “хаяг” болон “байршлын хаяг” гэсэн нэр томъёог хэрэглэсэн нь хоёр тусдаа ойлголт мэтээр хэрэглэж болохоор байгаа бөгөөд хаягийн мэдээлэл юуг агуулах талаар ойлгомжгүй байгаа нь хаягжуулах үйл ажиллагаанд ойлголтын зөрүү үүсэхээр болгосон. Тухайлбал, хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.7 дахь заалтад “хаяг” гэсэн үгийг хэрэглэсэн бол хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3, 4.4 дэх хэсэгт “байршлын хаяг” гэсэн үгийг хэрэглэсэн байх тул хуулиар “хаяг”, “хаягийн объект”, “хаягийн мэдээлэл буюу бүрдэл”, “хаягжуулалт”, “гудамж”, “талбай”, “хаягийн тэмдэг”, “хаягийн дугаар” гэх мэт нэр томъёог нарийвчлан томъёолох шаардлагатай байна.

Улсын хэмжээнд 5 төрлийн аргачлалаар хаяг олгож байгаа нь хаягийн давхардал, хаяг тодорхойгүй байх, хаягийн системүүд дэх мэдээлэл зөрүүтэй байх гэх мэт асуудлуудыг үүсгэж, Хаягжуулалтын тухай хуульд заасан хаягжуулах ажил нэгдсэн арга зүйтэй байх зарчмыг алдагдуулж байна. Тухайлбал, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар, Харилцаа холбооны зохицуулах хороо зэрэг байгууллага нь өөрсдийн эрхлэх асуудлын хүрээнд хаягийн мэдээллийн санг тус тус үүсгэсэн ч стандартын хувьд зөрүүтэй, харилцан уялдаагүй байна.

Үүний зэрэгцээ Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд (хуучин нэрээр)-ын 2007 оны 101 дүгээр тушаалаар анх “Шуудангийн нэгдсэн код”-ыг баталж байсан бөгөөд “Шуудангийн нэгдсэн код шинэчлэн батлах тухай” Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/24 дүгээр тушаалаар нийт 2721 шуудангийн нэгдсэн кодыг шинэчлэн баталсан. Энэ кодыг нэвтрүүлэх ажлыг Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтын дагуу Харилцаа холбооны зохицуулах хороо хариуцан ажиллаж байна.

“Монгол Улсын бүсчлэлийн код” (шуудангийн нэгдсэн код) нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн хуваарийн дагуу засаг захиргааны нэгжийн болон хот суурингийн хэсэг (бүс)-ийн байршлын тухай мэдээллийг агуулж, тэдгээрийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй уялдуулан зохицуулалт хийх, давхардуулахгүй оноох нөөц бүхий бүсчлэлийн 5 оронтой тоо байдаг байна.

Хэдийгээр холбогдох эрх зүйн актад шуудангийн нэгдсэн кодыг нэг объект буюу барилга, байгууламж, орон сууцанд хамаарахаар батлах, хэрэглэх зохицуулалт байхгүй байгаа боловч Харилцаа холбооны зохицуулах хороо болон Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газраас (хуучин нэрээр) 2022 оны байдлаар бүсчлэлийн 5 оронтой тоон дээр 4 оронтой тоо нэмж, нийт 9 оронтой тооноос бүрдсэн шуудангийн нэгдсэн кодыг 18,000 гаруй объектод олгосон байна.

Иймд хаягийн тэмдгийн стандарт, хаягжуулах аргачлалыг тодорхой болгох, шуудангийн нэгдсэн код буюу 5 оронтой тоог хаягийн мэдээлэл, бүрдэлд оруулж олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай юм.

Сүүлийн 10 жилийн хугацаанд гамшгийн хэмжээнд тооцогдох хүчтэй цасан болон шороон шуурга, аадар бороо, үерийн аюулт үзэгдлийн 1300-аад тохиолдол бүртгэгдсэн байна. Дээрх гамшигт үзэгдэлд нэрвэгдсэн олон зуун хүнийг эрэн хайх, аврах, тусламж үзүүлэхэд хаягийн мэдээлэл дутуу, замчлах систем хөгжөөгүйн улмаас цаг хугацаа алдах, улмаар хүний амь эрсэдсэн цөөнгүй тохиолдол бүртгэгдсэн байна.

Түүнчлэн манай улсын хувьд өргөн уудам нутаг дэвсгэртэй, малчид бэлчээрээ даган нүүдэллэн аж төрдөг онцлогтой учраас өвөлжөө, хаваржаанд хүрэх шороон замын мэдээлэл зураглагдаагүй байдаг тул тэдэнд замчлах системийг ашиглан шуудан, илгээмжийн болон хаягийн мэдээллийн дагуу бусад үйлчилгээг хүргэх боломжгүй байна.

Олон улсын жишигт нийцсэн хаягийн торлолын үндсэн зарчмыг хаягжуулалтад ашигласнаар өвөлжөө, хаваржаа, амралт, сувиллын газар, аялагч, амрагчдын отоглосон газар, цаашлаад төөрсөн хүнийг олоход тодорхой байршилд шууд хүрч очих боломж бий болох юм.

Иймд улсын хэмжээнд нийт нутаг дэвсгэрийг зураглаж үүсгэсэн торлолын дагуу замчлах системийг бий болгох, ашиглах, түүнийг хаягийн мэдээлэл, бүрдэлд оруулах асуудлыг хуульд тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дэлхийн улс, орнуудад хиймэл оюун ухаанд суурилсан, дэвшилтэд техник технологийг ашигласан өгөгдлийн санг бүрдүүлж, засаглал, шийдвэр гаргалтад болон шуудан, харилцаа, холбоо, үйлдвэрлэл, үйлчилгээнд өргөнөөр ашиглаж, өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, цэгцлэх ажилд онцгой анхаарал хандуулан, хөгжүүлж байгаа өнөөгийн нөхцөлд өгөгдлийн суурь мэдээлэл болох хаягийг бүрэн бүрдүүлэх, урт хугацаанд өөрчлөгдөхгүй, хөдөлгөөнгүй байдлаар ашиглагдах нөхцөлийг хангуулах нь чухал ач холбогдолтой байна.

1.2.2.Хаягийн мэдээллийн сан, систем, хаягжуулах үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг, үйл ажиллагааны уялдаа холбооны талаар:

Хуульд хаягжуулах үйл ажиллагаа, оролцогч талуудын эрх, үүрэг, үйл ажиллагааны уялдаа холбоо болон хаягийн мэдээллийн сан, хаягийн мэдээллийн систем бүрдүүлж, ашиглах зэрэг суурь асуудлыг бүрэн зохицуулж өгөөгүй нь хаягжуулах үйл ажиллагаанд оролцогч талуудын дунд ойлголтын зөрүү гарах, ажлын уялдаагүй байх, давхардал үүсэх зэрэг нөхцөл байдлыг бий болгосон байна. Тухайлбал, төрийн байгууллагууд өөр өөрсдийн эрхлэх асуудлын хүрээнд хаягийн мэдээллийн санг үүсгэн хэрэглэж байна.

Мөн гудамж, зам, талбай, орон сууцны хороолол, хотхон, барилга байгууламжийн нэр, дугаар, хаалганы дугаарыг ямар субъект, ямар зарчмаар өгөх, өөрчлөх, хадгалах, уялдуулах, хянах, мэдээллийн санг эрхлэх, ашиглах зэрэг нь тодорхойгүй байгаагаас үйл ажиллагааны давхардал үүсгэж, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ын дагуу аймгийн хэмжээнд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн хэмжээнд газарт буюу хашаанд байршлын хаяг олгохоор заасан үйл ажиллагаа хийгдэхгүй тус байгууллагууд нь сум, баг, хорооны Засаг даргаас өгсөн хаяг, хаягийн тодорхойлолтыг зөвхөн бүртгэх байдлаар үйл ажиллагааг эрхэлж байна.

Түүнчлэн дээрх байгууллагууд нь зөвхөн барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын комисс ажиллах шаардлагатай барилга

байгууламжид хаягийн дугаар өгч, бусад барилгад буюу хашааны хаягтай байршилд баригдсан барилгад тухайн объектын байрлах хашааны хаягийг үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий газраас үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг олгож байна. Өөрөөр хэлбэл гэр хороолол, зуслангийн бүсэд баригдсан барилга хаягийн дугааргүй, хашааны хаягаараа бүртгэгдэж байгаа гэсэн үг юм.

Дээрх дурдсанчлан, өөр өөр субъект нэгдсэн стандартгүйгээр, журам зөрчиж хаяг олгох, түр хаяг олгох болон нэр, дугааргүй задгай гэх зэргээр гудамж, хашааг нэрлэн хаягжуулж байгаа нь хаягийг хэрэглэхэд улам хүндрэлтэй, ойлгомжгүй байдал бий болгож, хаягийн давхардах үндсэн шалтгаан болж байна.

Хаягжуулалтын тухай хууль 2013 оноос хэрэгжиж эхэлснээр газар нутаг, суурин газарт байгаа гудамж, зам, талбай, үйлдвэр, аж ахуйн нэгж, хотхон, төлөвлөлтгүй суурьшсан хэсэг, үл хөдлөх эд хөрөнгийн нэр, дугаарыг төлөвлөж хаягийн төслийн байр зүйн сэдэвчилсэн зураг үйлдэх, хаягийн мэдээллийг Газрын кадастрын мэдээллийн санд оруулах, хаягийн жагсаалт хэвлэх асуудлыг журамлаж, 2013 оноос хаягийн мэдээллийн санг улсын хэмжээнд бүрдүүлж эхэлсэн.

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар 21 аймаг 330 сумын хаягийн мэдээлэл бүхий хаягийн мэдээллийн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд 2024 оны байдлаар улсын хэмжээнд нийт 100,973 гудамж, 969,678 нэгж талбар, барилга, өвөлжөө, хаваржаа, тариалангийн газарт шинэ хаяг олгож Хаягжуулалтын тухай хууль, журмын дагуу нэрлэж, дугаарлан хаягжуулсан байна.

Гэвч эрх зүйн орчин, зохицуулалт хангалтгүй байгаагаас шалтгаалан төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд өөрсдийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан нэгдсэн өгөгдлийн стандартгүйгээр тус тусдаа хаягийн мэдээллийн санг бүрдүүлж, системийг хөгжүүлж, ашиглаж байна. Тухайлбал, улсын хэмжээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын “Хаягийн мэдээллийн систем”, нийслэлд Хот байгуулалт, хөгжлийн газраас хөгжүүлсэн “Хаягийн мэдээллийн сан” гэсэн хоёр үндсэн системийг хаягжуулалтад ашиглаж байна. Мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Хаягийн мэдээллийн систем, Харилцаа холбооны зохицуулах хорооны Шуудангийн нэгдсэн кодын мэдээллийн сан, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн систем дэх хаягтай холбоотой бүртгэлүүд нэгдсэн өгөгдлийн стандартгүйгээр хийгдэж байна.

Улсын хэмжээнд Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй нийт 1,292,329 газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн мэдээлэл байгаагаас эзэмших, ашиглах эрх үүссэн 644,996, өмчлөх эрх үүссэн 647,333 нэгж талбар байх бөгөөд өмчлөх эрх үүссэн нэгж талбараас Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн санд 543,292 газар өмчлөгчийн мэдээлэл бүртгэлтэй байна. Тус 2 байгууллагын мэдээллийн сангийн хаягийн мэдээлэлд тулгалт хийж үзэхэд 40.8% буюу 264,056 нэгж талбарын хаяг таарч, үлдсэн 59.2% буюу 383,277 нэгж талбарын хаягийн мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн байна.

Хувийн хэвшлийн тухайд өөрсдийн бизнесийн үйл ажиллагаанд ашиглах хаягийн суурь мэдээллийг бүрдүүлэхийн тулд зарим аж ахуйн нэгж (“ICTGroup” ХХК, “Монгол АйДи” ХХК, “Юбикаб холдинг” ХХК) газар дээр нь очиж өгөгдөл цуглуулан хаягийн зураг хийж, систем (imaps.mn, minumaps.mn) хөгжүүлсэн байна.

Түүнчлэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил зааг, нэр өөрчлөгдөхөд хаягийг хэрхэн өөрчлөх, хаяг өөрчлөгдсөнтэй холбоотой үүсэх үйл

ажиллагааны талаар хуульд зохицуулаагүй байна.

Иймд улсын хэмжээнд орон зайн мэдээлэлд суурилсан нэг хаягийн мэдээллийн системийг бий болгож, ашиглах, хаягжуулалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой болгох, хаяг олгох үйл ажиллагааг хүнээс хамаарахгүйгээр системээс шууд олгодог тогтолцоонд шилжих, хаалга бүрд очих боломжтой 3 хэмжээст хаягийн системийн зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна.

1.2.3.Бусад

Хаягжуулалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад “хаяг үнэн зөв, энгийн, ойлгомжтой байх” зарчмыг тусгасан боловч практикт дээрх зарчим бүрэн биелэхгүй байна. Тухайлбал, хүүхэд, залуучуудад хаягийн талаарх ойлголт мэдлэг олгох арга хэмжээ дутмаг, хүн хэлэх, уншихад төвөгтэй, хэт урт үгийг хаягжуулалтад ашигласаар байна. Жишээ нь, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, Энгельсийн гудамж, Ерөнхий сайд асан Ц.Жигжиджавын гудамж, Хичээнгүй сайд Цэрэндоржийн гудамж, Дилав хутагт Жамсранжавын гудамж, Жалханц хутагт Дамдинбазарын гудамж, Денверийн гудамж, Ноён хутагт Данзанравжаагийн гудамж, Намъянжугийн гудамж г.м.

Иймд сургуулийн өмнөх боловсрол олгох байгууллага, ерөнхий боловсролын сургалтаар дамжуулан хүүхдэд хаягийн талаарх ойлголт мэдлэгийг олгох нь зүйтэй бөгөөд энэ нь хүүхдийг аливаа эрсдэлээс хамгаалахад чухал ач холбогдолтой болох юм.

Мөн хуулиар албан ёсны хаягийн нэр, хүндэтгэлийн нэрийн ялгааг гаргаж, хүн хүүхэд хэлэх, тогтоох, уншихад хялбар нэрийг ашиглах, цаашлаад хаягийн тэмдэгт байршуулахад тохиромжтой байх зорилгоор үсэг, тэмдэгтийн хязгаарыг тогтоож стандартчилах шаардлагатай байна.

Түүнчлэн хаягжуулах үйл ажиллагаа нь тодорхой санхүүжилтийн эх үүсвэрийг шаардах бөгөөд хаягийн объектын эзэмшигч, ашиглагч, өмчлөгчөөс үл шалтгаалсан өөрчлөлтийн үед тухайн зардлыг холбогдох байгууллага хариуцдаг байх, бусад тохиолдолд хаягийн объектын эзэмшигч, ашиглагч, өмчлөгч хариуцах талаар хуульд тусгах шаардлагатай юм.

Хаягийн тэмдэг, тэмдэглэгээний стандартыг нарийвчлан баталж, нэгдсэн аргачлалаар байршуулах ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог хангах талаар мөн хуульд тусгах шаардлагатай байна.

Мөн иргэний оршин суугаа газрын болон хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулж байгаа барилга байгууламжийн байршлаар албан ёсны хаягийг бүртгэх талаар зохицуулалт байхгүй, төрөөс албан ёсны хаягийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгоогүйн улмаас хувийн хэвшил өөрсдийн хөрөнгөөр itar.mn, minutar.mn, UbCab зэрэг хаяг, байршлын мэдээллийн системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлж байгаа нөхцөл байдал үүсэж байна.

Иймд хаягийн мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй болгох талаар хуульд тусгах шаардлагатай байна.

Хаягжуулалттай холбоотой дээр дурдсан практик хэрэгцээ, шаардлага, нөхцөл байдлыг эрх зүйн хүрээнд тодорхой болгож, нарийвчлан оновчтой зохицуулах зорилгоор Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хаягжуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн судалгааны үр дүнд 2013 онд баталсан, хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа Хаягжуулалтын тухай хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт оруулахаар байгаа тул Хаягжуулалтын тухай хуулийн төслийг хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөл нь 6 бүлэгтэй байх бөгөөд дараах зохицуулалтыг тусган боловсруулна.

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилт, хаягжуулалтын хууль тогтоомж, нэр томъёоны тодорхойлолт, хаягжуулалтад баримтлах зарчмыг; Хоёрдугаар бүлэгт хаягийн объект, хаягийн бүрдэл, хаягийн тэмдгийг; Гуравдугаар бүлэгт хаягжуулах аргачлалыг; Дөрөвдүгээр бүлэгт төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг, зохион байгуулалт; Тавдугаар бүлэгт хаягийн мэдээллийн сан, системтэй холбоотой зохицуулалтыг; Зургаадугаар бүлэгт бусад зүйл буюу хаягийн үйл ажиллагааны санхүүжилт, хориглох үйл ажиллагаа, хүчин төгөлдөр болох хугацаа зэргийг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Хуулийн төсөл батлагдсанаар орон зайн мэдээлэлд суурилсан хаягийн мэдээллийн нэг системийг бий болгох, нэгдсэн стандарт, аргачлалаар хаягжуулах, хаягийн мэдээллийг нээлттэй болгох замаар шуудан, төрийн үйлчилгээ, онцгой байдлын үед авах тусламж, үйлчилгээ, цахим худалдааны үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлснээр нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

Хаягийн суурь мэдээллийг практик шаардлагад нийцүүлэн, олон улсын стандартын дагуу бий болгож, нэг эх сурвалжаас бодит тухайн агшинд нээлттэй хэрэглэх боломжоор хангаснаар хаяг үнэн зөв байх, дэлхийн олон оронд чиг хандлага болж байгаа хаяг, байрлалын мэдээлэлд суурилсан бизнес моделиуд манай улсын зах зээлд нэвтрэх боломж нэмэгдэнэ.

Хаягийн мэдээллийн системийн удирдлага, зохион байгуулалт, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлсноор хаягийг хүнээс хамаарахгүйгээр системээс шууд олгодог тогтолцоонд шилжиж, хаалга бүрд очих боломж бүхий 3 хэмжээст хаягийн систем бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Уг хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Шуудангийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Авто замын тухай хуульд өөрчлөлт

оруулах хуулийн төслүүд болон Хаягжуулалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

—oOo—



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

ХАЯГЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 ОН

АГУУЛГА

Удиртгал

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ХОЁР.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

- 1.1.Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох
- 1.2.Үнэлгээ хийх хүрээг тогтоох
- 1.3.Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох
- 1.4.Харьцуулах хэлбэрийг сонгох
- 1.5.Шалгуур үзүүлэлтийг томъёолох
- 1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

ГУРАВ.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ДӨРӨВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

- 4.1.“Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал
4. 2.“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

ДӨРӨВ.ЗӨВЛӨМЖ

- 4.1.Зөвлөмж

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

УДИРТГАЛ

“Эрхэт Инноваци” ХХК нь Барилга, хот байгуулалтын яамтай 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан 2023/21 дугаар гэрээний дагуу Хаягжуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-аар үнэлгээ хийлээ.

Үнэлгээ хийх энэхүү ажил нь Хаягжуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийх, хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж дүгнэлт, зөвлөмж өгөх зорилготой.

Хаягжуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь Аргачлалын 2.1-д заасны дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн.

Нэг.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1.Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Монгол Улсын Их Хурлаас Хаягжуулалтын тухай хуулийг 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталж, дагаж мөрдөж эхэлснээс хойших 12 жилийн хугацаанд түүнд 2 удаа /2015, 2022 онуудад/ өөрчлөлт оруулсан байх бөгөөд уг өөрчлөлтүүд нь бусад хуулийг дагалдуулж оруулсан өөрчлөлт байна.

Хаягжуулалтын тухай хууль “Хуулийн зорилт”, “Хаягжуулалтын тухай хууль тогтоомж”, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулахад баримтлах зарчим”, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулах”, “Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага” гэсэн 5 зүйл, 22 заалттай.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ.” гэж заасан байдаг ч Хаягжуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт тусгайлан үнэлгээ хийгдээгүй байна.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн дээрх заалтыг үндэс болгон Хаягжуулалтын тухай хууль дахь зарим зохицуулалтын хүрээнд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсэн болно.

1.2.Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаагаар тухайн хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Энэ үе шатны хүрээнд Хаягжуулалтын тухай хуулиар зохицуулсан үндсэн харилцаа, зохицуулалтуудыг аль болох агуулгын хувьд бүхэлд нь үнэлэхийг хичээж үнэлгээ хийх хүрээг тус хуулийн дараах зүйл, заалтаар тогтоолоо. Үүнд:

№	Үнэлэгдэх	
	зүйл	хэсэг, заалт
1	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт	1.1.Энэ хуулийн зорилт нь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
2	3 дугаар зүйл. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулахад баримтлах зарчим	3.1.Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулахад дараах зарчим баримтална:
		3.1.3.хаяг давхардахгүй байх;
		3.1.4.хаяг үнэн зөв, энгийн, ойлгомжтой байх;
		3.1.5.кадастрын бүртгэлээр баталгаажсан байх;
		3.1.6.хаягжуулах ажил нэгдсэн арга зүйтэй байх;
3	4 дүгээр зүйл. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулах	3.1.7.хаягийн талаарх мэдээлэл хүртээмжтэй, нээлттэй байх.
		4.7.Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар батална.
		4.8.Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

1.3.Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

Аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлт бүр хуулийн хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход чиглэсэн байх тул Хаягжуулалтын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг харгалзан, түүнчлэн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран Аргачлалын 3.4-т заасан 6 шалгуур үзүүлэлтээс дараах 2 шалгуур үзүүлэлтийг сонгож авсан. Үүнд:

1/Зорилгод хүрсэн түвшин. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоодог. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд зохимжтой гэж үзэж сонгосон болно. Өөрөөр хэлбэл, энэ шалгуур үзүүлэлтээр Хаягжуулалтын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд анх батлах үед төлөвлөж байсан зорилгод хүрсэн эсэхийг тогтоох боломжтой.

2/Практикт нийцэж байгаа байдал. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хаягжуулалтын тухай хуулийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно.

№	Үнэлгээний хүрээ		Шалгуур үзүүлэлт
	зүйл	хэсэг, заалт	
1	1 дүгээр зүйл	1.1 дэх хэсэг	Зорилгод хүрсэн түвшин

2	3 дугаар зүйл	3.1 дэх хэсгийн 3.1.3-3.1.7 дахь заалт	Практикт нийцэж байгаа байдал
3	4 дүгээр зүйл		Зорилгод хүрсэн түвшин Практикт нийцэж байгаа байдал

1.4.Харьцуулах хэлбэрийг сонгох

Аргачлалын 3.5.1-д заасны дагуу хууль хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг.

Хаягжуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхэд түүний хэрэгжилттэй холбоотой үүссэн асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлтээс хамаарч Аргачлалын 3.5.3-т заасан:

1/“байх ёстой ба одоо байгаа”

2/“хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш”

3/“хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш”

4/“тохиолдол судлах” гэсэн 4 харьцуулах хэлбэрээс “байх ёстой ба одоо байгаа”, “тохиолдол судлах” гэсэн харьцуулах хэлбэрүүдийг сонгосон болно.

“**Байх ёстой ба одоо байгаа**” харьцуулах хэлбэрийн хүрээнд Хаягжуулалтын тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн 2013 оноос хойш гарсан үр дагавар /одоо байгаа нөхцөл байдал/-ыг бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийг тухайн хуулиар тогтоосон шаардлага, хэмжиж болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хуулийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохыг зорьсон.

“**Тохиолдол судлах**” харьцуулах хэлбэрээр Хаягжуулалтын тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалт нь өөр өөр нөхцөл буюу тохиолдолд хэрхэн хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Төлөвлөх үе шат			
№	Үнэлгээний хүрээ	Тогтоосон шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэрийг сонгох
	1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг	Зорилгод хүрсэн түвшин	Байх ёстой ба одоо байгаа
	3 дугаар зүйлийн 3.1.3-3.1.7 дахь заалт	Практикт нийцэж байгаа байдал	Байх ёстой ба одоо байгаа
	4 дүгээр зүйлийн 4.7, 4.8 дахь хэсэг	Практикт нийцэж байгаа байдал	Тохиолдол судлах

1.5.Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Энэ ажиллагааны хүрээнд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлэх, эсхүл асуулт тавьж, уг үнэлгээний хүрээнд Хаягжуулалтын тухай хуулийн бүтэц, агуулга, зохицуулалтын шинж чанар, онцлогоос хамаарч аль тохиромжтой буюу түүгээр хэрэгжилтийн үр нөлөө, үр дагавар нь гарч ирэх шалгуур

үзүүлэлтийг сонгодог. Тухайлбал, шалгуур үзүүлэлтийг хамаарах зохицуулалтад “Зорилтод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал ямар байна вэ?”, “Практикт хэрхэн нийцэж байна вэ?” зэрэг асуултын хүрээнд томъёолж гүйцэтгэсэн болно.

1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Аргачлалын 3.7.3.1-д заасан мэдээлэл цуглуулах аргын тухайд “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах” аргыг сонгосон бөгөөд ингэхдээ өмнө хийгдсэн судалгааны тайлангуудын мэдээллийг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласнаас гадна статистик тоо баримт, гадаадын зарим улс орнуудын туршлагыг судалж ашигласан.

Хоёр.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд мэдээлэл цуглуулах аргыг ашиглан судалгааны хэрэгжүүлэх үе шатны холбогдох ажиллагаануудыг хийж гүйцэтгэлээ. Хаягжуулалтын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай болон байгаа мэдээллийг цуглуулах аргаар дараах холбогдох материалыг цуглуулан дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

1.Монгол Улсын хууль:

- 1/Монгол Улсын Үндсэн хууль
- 2/Геоземи, зураг зүйн тухай хууль /1997 он/
- 3/Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль /1999 он/
- 4/Газрын тухай хууль /2002 он/
- 5/Шуудангийн тухай хууль /2003 он/
- 6/Хот байгуулалтын тухай хууль /2008 он/
- 7/Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /2015 он/
- 8/Авто замын тухай хууль /2017 он/
- 9/Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /2020 он/
- 10/Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /2021 он/
- 11/Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /2024 он/.

2.Монгол Улсын засгийн газрын тогтоол:

- 1/“Журам батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 280 дугаар тогтоол /Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам/-/2019 оны 325 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/
- 2/“Журам шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 325 дугаар тогтоол /Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам/

3.Бусад:

1/“Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага MNS5283:2022” стандарт

2/“Хаягийн бичвэрт тавих шаардлага MNS6775:2019” стандарт

3/Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэл Улаанбаатар хотын гудамж, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох, барилга, байгууламжид дугаар олгох журам”

4.Ашигласан цахим хуудас:

Гурав.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Энэ үе шатанд Төлөвлөх үе шатанд сонгож авсан үнэлгээний хүрээ буюу Хаягжуулалтын тухай хуулийн зүйл, хэсэг, заалт тус бүрийг хэрэгжүүлэх үе шатанд олж авсан мэдээлэл дээр тулгуурлан үнэлсэн болно.

Монгол Улсын Их Хурал Хаягжуулалтын тухай хуулийг 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталсан бөгөөд түүнд 2 удаа /2015, 2022 онуудад/ өөрчлөлт оруулсан байна.

Хаягжуулалтын тухай хууль “Хуулийн зорилт”, “Хаягжуулалтын тухай хууль тогтоомж”, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулахад баримтлах зарчим”, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулах”, “Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага” гэсэн 5 зүйл, 22 заалттай.

Хаягжуулалттай холбогдсон харилцааг Хаягжуулалтын тухай хуулиас гадна Геодези, зураг зүйн тухай хууль /1997 он/, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль /1999 он/, Газрын тухай хууль /2002 он/, Шуудангийн тухай хууль /2003 он/, Хот байгуулалтын тухай хууль /2008 он/, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /2015 он/, Авто замын тухай хууль /2017 он/, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /2020 он/, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /2021 он/, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /2024 он/ зэрэг хуулиар зохицуулж байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Хаягжуулалтын тухай хуулийн зохицуулалтууд мөн хуулийн зорилтыг хангаж чадаж байгаа эсэх, хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд хуулийн зорилго, зорилтод хүрсэн эсэх?

Хаягжуулалтын тухай хуулиас үнэлгээ хийхээр сонгож авсан эхний хуулийн заалт бол “Хуулийн зорилт” гэсэн 1 дүгээр зүйл байгаа.

Хаягжуулалтын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан.

Хэдийгээр тодорхой хэмжээнд эрх зүйн орчин бүрдсэн ч хуулийн бүтэц хэт ерөнхий, талаас илүү хувийг зарчим, тунхагийн шинжтэй зохицуулалт эзэлсэн байх бөгөөд хаягжуулалттай холбоотой нэр томьёо, нэгдсэн аргачлал, хаягжуулах үйл ажиллагаа, оролцогч талуудын эрх, үүрэг, уялдаа холбоо, хаягийн мэдээллийн сан, хаягийн мэдээллийн систем, нээлттэй мэдээлэл, тэмдэг, тэмдэгжүүлэлт, шуудангийн хайрцгийн хэрэглээ зэрэг суурь асуудлуудыг бүрэн зохицуулж өгөөгүй байна.

Хаяг нь нийгэм, эдийн засагт өргөн хэрэглэгддэг өдөр тутмын хэрэглээ бөгөөд энэхүү суурь харилцаанд нийгмийн олон талын оролцогч байдаг боловч хуульд нэр томьёотой холбоотой зүйл, заалт оруулж өгөөгүй нь хуулийг субьектив байдлаар ойлгох, тайлбарлах, хэрэглэх, нийтийн хэрэглээнд ойлгомжгүй байх, төрийн эрх бүхий байгууллагуудын хооронд ойлголтын зөрүү үүсэх, уялдаа холбоо алдагдах зэрэг нөхцөл байдлыг бий болгожээ.

Хуульд “үл хөдлөх эд хөрөнгө” гэсэн нэр томьёоноос өөр нэр томьёог тодорхойлоогүй байна.

Тус хуульд хаягжуулах объектыг гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө гэж тодорхойлсон боловч “гудамж”, “зам”, “талбай” , “өргөн чөлөө”, “туслах зам”, “мухар зам” гэж юуг ойлгох талаар нэр томьёог тодорхойлж өгөөгүй нь хуулийг хэрэгжүүлэхэд ойлгомжгүй байдал үүсгэж байна. Тухайлбал, хаягжуулалтын суурь нь зам бөгөөд зам нь өөрөө төрөлтэй, түүний нэг төрөл нь гудамж гэж ойлгож, хэрэглэж байгаа практик олон улсад байна. Мөн “талбай” гэдэгт ногоон байгууламж, авто зогсоол, цэцэрлэгт хүрээлэн зэрэг ямар объектууд орох талаар тодорхой зааж өгөөгүй байгаа юм.

Харин Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад "авто зам" гэж тээврийн хэрэгсэл зорчиход зориулан барьсан замын байгууламж бүхий хатуу, хайрган хучилттай зам, гудамж, засаж, сайжруулсан болон ердийн хөрсөн замыг” гэж, **Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад “”зам” гэж тээврийн хэрэгслээр зорчиход зориулсан зурвас газрыг. Зорчих хэсэг болон түүний хажуугийн хөвөө, явган хүний зам, тусгаарлах зурвас замд хамаарна.”** гэж тус тус тодорхойлсон байна.

Түүнчлэн хуульд “хаяг” болон “байршлын хаяг” гэсэн нэр томьёог хэрэглэсэн нь хоёр тусдаа ойлголт мэтээр хэрэглэж болохоор байна. Тухайлбал, хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.7 дахь заалтад “хаяг” гэсэн үгийг хэрэглэсэн бол хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3, 4.4 дэх хэсэгт “байршлын хаяг” гэсэн үгийг хэрэглэсэн байна.

Хаягжуулалтын хуулийн зорилтыг нь хаягийн объект (зам, гудамж, өргөн чөлөө, үл хөдлөх эд хөрөнгө)-ийг хаягжуулах, нийтэд нээлттэй болгох ажлыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тодорхойлсон байгаа тул энэхүү судалгааны ажлын дараагийн хэсгээр хуулийн зохицуулалтад хийсэн үнэлгээнүүдээр хуулийн хэрэгжилт зорилгодоо хүрсэн эсэхийг тодорхойлох боломжтой.

Үнэлгээ:

Хаягжуулалтын тухай хуулийн 1 зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон ч нэр томьёо, аргачлал, мэдээллийн сан, оролцогч, талуудын эрх, үүрэг зохицуулах харилцааг орхигдуулсан нь зорилттойгоо нийцэхгүй байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. Хуульд заасан гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулахад баримтлах зарчмууд практикт хэрэгжиж байгаа эсэх?

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд зорилтоо хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн 7 зарчмыг тодорхойлж өгсөн байна.

3.1.Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулахад дараах зарчим баримтална:

- 3.1.1.байр зүйн зурагт суурилсан байх;
- 3.1.2.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарьт нийцсэн байх;
- 3.1.3.хаяг давхардахгүй байх;
- 3.1.4.хаяг үнэн зөв, энгийн, ойлгомжтой байх;
- 3.1.5.кадастрын бүртгэлээр баталгаажсан байх;
- 3.1.6.хаягжуулах ажил нэгдсэн арга зүйтэй байх;
- 3.1.7.хаягийн талаарх мэдээлэл хүртээмжтэй, нээлттэй байх.

Хаягжуулалтын тухай хуулийн 7 зарчмын нэг болох “байр зүйн зурагт суурилсан байх,” гэсэн зарчмыг улсын төсвийн хөрөнгөөр 2013-2017 хэрэгжсэн “Хаягийн мэдээллийн систем байгуулах” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд баримталсан байна. Гэвч байршилд суурилсан хаягжуулалтын суурь мэдээлэл болох 1:1000-ны масштабтай байр зүйн зураг /суурин газрын хувьд/ нь тухай үед бүх сум, суурин газарт зохиогдоогүй, шинэчлэгдээгүй, нэгдсэн тогтолцоо /“Геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгсэн тогтолцоог батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоол/-нд шилжээгүй, Нийслэлийн хувьд БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг KOICA байгууллагын тусламжаар хэрэгжсэн Улаанбаатар хотын 1:1000-ны масштабтай байр зүйн зураг хийх, мэдээллийн сан үүсгэх төсөл, арга хэмжээний хүрээнд Нийслэл Улаанбаатар хотын 1:1000-ны масштабтай зураг зөвхөн төвийн хэсгийг хамарсан талбайд хийгдсэн байна.

Хаягжуулалтын тухай хуульд заасан хаягжуулалтад баримтлах зарчмууд нь зорилтдоо хүрэх арга замтайгаа зөрчилдөж байгаа байдал харагдаж байна. Тухайлбал, хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтад **“хаягжуулах ажил нэгдсэн арга зүйтэй байх”** гэсэн зарчмыг тодорхойлж өгсөн. Гэхдээ ямар арга зүйгээр хаягжуулалтыг хийх талаар тусгаагүй, өөрөөр хэлбэл, нэгдсэн арга зүйг хуульчлаагүй, үүнийг Засгийн газар шийдвэрлэхээр заасан байна.

Хаягжуулалтын хууль хэрэгжиж эхэлснээс хойш хаягжуулалтыг зохицуулж байгаа Засгийн газраас баталсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам” 2 удаа өөрчлөгдөөд байгаа ба үүний үр дүнд хэд хэдэн арга зүйгээр хаягжуулалт хийгдсэн байна.

Үүнтэй холбоотойгоор хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад заасан **“хаяг үнэн зөв, энгийн, ойлгомжтой байх”** гэсэн зарчим бүрэн хэрэгжих боломжгүй байдал үүссэн байна.

Түүнчлэн **“хаяг кадастрын бүртгэлээр баталгаажсан байх”** гэдэг зарчим хэрэгжихэд Монгол Улсын бүртгэлийн тогтолцооны онцлог буюу төрийн хоёр тусдаа байгууллага хийж байгаа нь хүндрэл учруулж байна. Тиймээс хаягийг бүртгэх мэдээллийн сангийн асуудлыг хуульд тусгах, түүнийг хэрхэн тогтвортой авч явах, бусад мэдээллийн сантай уялдах талаар зохицуулалт хийх шаардлагатай байна.


Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтад **“хаягийн талаарх мэдээлэл хүртээмжтэй, нээлттэй байх”** гэж заасан ч хэрхэн, яаж хүртээмжтэй, нээлттэй байх, хэн хариуцах зэрэг нь тодорхой бус байна.

Мөн энэхүү заалтыг Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн заалттай уялдуулах шаардлагатай. Тухайлбал, энэ хуулиар “хөрөнгийн мэдээлэл”, “хүний хувийн мэдээлэл” зэрэг ойлголтуудыг зохицуулж байгаа бөгөөд эдгээр мэдээллийг хүний зөвшөөрлөөр цуглуулах, боловсруулах тухай заажээ.

Хэдийгээр хаягийн мэдээллийн санг 2013 оноос эрчимтэйгээр бүрдүүлж ирсэн ч хаягийн мэдээлэл, мэдээллийн сан олон нийтэд хаалттай байсаар байна. Иргэд, төр болон хувийн хэвшил хаягийг нийгэм, эдийн засаг, байгаль орчны олон харилцаанд ашиглаж байна. Тухайлбал, оршин суугаа газрын тодорхойлолт, нийгмийн суурь үйлчилгээ, шуудан, илгээмж хүргэлт, онлайн худалдан авалт, нийтийн тээвэр, такси үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгийн түрээс, зуучлал, аялал жуулчлал, онцгой байдал, татвар, төлбөр болон бусад олон төрлийн үйл ажиллагаанд хаяг хэрэглэгдэж байна.

Гэсэн хэдий ч хаягийн мэдээллийн санг бүрдүүлэгч, эрхлэгч гол тоглогч болох төр нь иргэд олон нийт, хувийн хэвшлийн хэрэглээнд хаягийн мэдээллийн санг нээлттэй болгож чадаагүй байна. Түүнчлэн одоогийн үүсгэсэн хаягийн мэдээллийн сангийн хаягийн бүрэлдэхүүн болон геометр утга, хэлбэр, агуулга нь хувийн хэвшлийн хэрэгцээ, шаардлагыг хангахгүй байна.

Хаягийн хэрэглээ болох шуудан, илгээмж хүргэлт, онлайн худалдаа, такси үйлчилгээ, суурь байршлын мэдээллийн зах зээл жил ирэх тусам өсөж байна. Тухайлбал, шуудан, илгээмжийн зах зээлийн сүүлийн жилүүдэд тогтвортой өсөж байгаа нь харагдаж байна. Монгол шуудан ХК-ийн дотоод шуудангийн солилцооны тоо 2017 онд 1.2 сая байсан бол 2021 онд ойролцоогоор 2 дахин өссөн байна. Нийт орлогын хэмжээ 2017 онд 13.7 тэрбум төгрөг байсан бол тогтвортойгоор өсөж 2021 онд 21 тэрбум төгрөгт хүрж 50 орчим хувиар өссөн байна (Эх сурвалж: Монгол шуудан ХХК-ийн 2022 оны тайлан). Цаашид ч өсөх хандлага ажиглагдаж байна.



Зураг 2. Дотоод шуудангийн солилцоо ба нийт орлого, Эх сурвалж: “Монгол шуудан” ХХК-ийн 2022 оны тайлан

Хэдийгээр шуудан, илгээмжийн тоо өсөж байгаа ч хаягийн мэдээллийн сангийн хэрэглэх боломж хомс байна. Тухайлбал, “Монгол шуудан” ХК-аар шуудан, илгээмж илгээх хүсэлт тус компанийн сайтаар дамжуулан өгөхөд хаягийн албан ёсны санг санал болгох боломж бүрдээгүй байгаа юм.

← → Not secure | mydelivery.mn/customer-order

MY DELIVERY

Захиалга үүсгэх | Төлбөр төлөх | Дуусгах

Илгээгч | Хаяг сонгох

* Нэр: * Хаяг дэлгэрэнгүй: Олимп хотхон

* Утас: Утас 1 Утас 2 what3words:

* Зил код: Улаанбаатар хот / Сүхбаатар дүүрэг...


Хүлээн авагч | Хаяг сонгох

Зураг 3. Илгээмж захиалгын хуудас, mydelivery.mn

Түүнчлэн албан ёсны хаягийн мэдээлэл нийтэд хаалттай байгаа нь хувийн хэвшил өөрсдийн хөрөнгийн эх үүсвэрээр хаяг, байршлын мэдээллийн сан хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлэх нөхцөл байдал руу оруулсан байна. Тухайлбал, itar.mn, minutar.mn, google.map, UbCab зэрэг хаяг, байршлын мэдээллийн санг ашиглаж, хөгжүүлж байгаа технологийн компаниудыг дурдаж болохоор байна. Үүний улмаас дээрх орон зайн мэдээллийн технологийг хөгжүүлж байгаа компаниудыг үндсэн үйл ажиллагаанаасаа гадна хаягийн сан хөгжүүлэх, томоохон зардал гаргах, эсвэл өөр зах зээл рүү орох нөхцөл рүү хөтөлж байна.

“ICTGroup” ХХК-ийн 10 жилийн турш хөгжүүлж байгаа iMap.mn нь байрлалд суурилсан томоохон систем бөгөөд тус газар зүй, орон зайн мэдээллийн системийн санд Монгол Улсын 21 аймаг, 330 сум, 1564 баг болон гол, нуур, худаг, уул, нутгийн нэршил, хаялбар шугам, хотын хаягжилтыг бүрэн багтаасан, нийт 323,785 хаяг, байршлын мэдээлэл бүртгэгдээд байна (Эх сурвалж: www.ictgroup.mn). 10 жилийн хугацаанд тус системийг хөгжүүлэх, өгөгдөл бүрдүүлэх цалингийн зардал нь тэрбум төгрөгөөс хол давсан байна.

Зураг 4. ICTGroup-ийн хөгжүүлсэн iMap.mn хаяг, байршлын систем




Мөн хаяг, байршлын minimap.mn мэдээллийн системийг “Монгол АйДи” ХХК хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. Тус системд агуулагдах бизнесийн үйл ажиллагаа болон хаягийн суурь мэдээллийг объект тус бүрээр явж, нэг бүрчлэн бүрдүүлсэн талаар дурдсан байгаа ба энэ системд оруулсан хөрөнгө оруулалт мөн хэдэн тэрбум төгрөгөөр хэмжигдэхээр байна.

Зураг 5. Монгол АйДи ХХК хаяг, байршлын minimap.mn мэдээллийн систем

Түүнчлэн UbCab нь зах зээлээ тэлэх, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрсдийн хөрөнгийн эх үүсвэрээр хаяг, байршлын мэдээллийн санг хөгжүүлэх шаардлага тулгарсан ба сүүлийн хэдэн жилийн хугацаанд ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулжээ. Нөгөөтээгүүр, навигацчиллын шаардлага хангахуйц хаягийн суурь мэдээлэл бүрдүүлж чадахгүй байгаа нь энэ төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвслүүдэд бизнесийн таагүй орчныг бий болгож байна. Тухайлбал, зам, замын нэр, төрөл (зам, гудамж, өргөн чөлөө, туслах зам, мухар зам,... гэх мэт), түүний нарийвчилсан мэдээлэл (геометр – эхлэл, төгсгөл цэг, төв цэг, чиглэл, нэгж талбар, барилга руу холбогдох цэг, орц, гарцын цэгэн утга, координат..... гэх мэт), орон сууц, барилга, гэр хороолол, зуслангийн дугаарлалт зэрэг мэдээлэл бүрэн бүрдээгүй байна.

Зураг 6 UbCab апп хаягийн сан орсон байдал



UbCab апп-аас хот, суурингийн төвийн хэсгийн барилга, орон сууцны хаягийн дугаарлалтын ихэнх нь орсон байгаа нь харагдаж байна.

Онлайн худалдааны хувьд дотоодын онлайн худалдаа, хүргэлтийн зах зээлийн талаарх албан ёсны мэдээлэл байхгүй байгаа ч Монгол банкнаас 2020 онд гаргасан “Цахим худалдааны статистик бүртгэлийн шинжилгээ”-нээс харахад манай улсын иргэд 2019 онд нийт 71.5 сая ам.долларын цахим худалдан авалтыг гаднын орноос хийсэн ба энэхүү тоо өсөх хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, дэлхийн олон оронд онлайн худалдаа нийт худалдааны 20%-ийг эзэлдэг талаарх судалгаа байдаг ба манай улсад 14.3 сая ам.доллар онлайн худалдаагаар хийгдэж байна. Энэхүү худалдааны хүргэлтийн үйл ажиллагаанд хаягийг түгээмэл хэрэглэж байгаа ч хаягийн үнэн зөв, албан ёсны эх үүсвэр бүхий мэдээлэл хаалттай байна.

Түүнчлэн хаягийн мэдээллийн нэг том хэрэглэгч нь үл хөдлөх эд хөрөнгийн салбар, тэр дундаа үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын салбар юм. Тус зах зээлд олон улсын франчайз болох Ремакс, C21 орж ирснээр технологи болон менежментийн олон боломжуудыг авчирчээ. Үүний нэг нь үл хөдлөх эд хөрөнгийн зарын нэгдсэн бүртгэл мэдээллийн сан ба цаашдын чиг хандлагын нэг гол зорилт нь орон зайн мэдээллийн систем хөгжүүлэх байна. Сүүлийн үеийн үл хөдлөх эд хөрөнгийн зарын нэгдсэн бүртгэлийн веб системүүдэд газар зүйн мэдээлэл, байрлалд суурилсан мэдээллийг нэвтрүүлж байгаа практик түгээмэл харагдаж байна.

Дээрх хэдхэн компанийн жишээнээс харахад хаягийн мэдээлэл, хаягийн сан бүрдүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гаргасан нь харагдаж байгаа юм.

Технологийн хурдацтай хөгжилтэй холбоотойгоор дэлхийн олон оронд тренд болж байгаа хаяг, байрлалын мэдээлэлд суурилсан дээрх бизнес моделиуд болон бусад Airbnb, booking.com, Uber, Amazon delivery, Ubereats, Baidu Map манай улсын зах зээлд нэвтрэх чиг хандлага харагдаж байгаа ба төрийн зүгээс бизнесийн таатай орчин бүрдүүлэх, суурь мэдээллийг практик шаардлагад нийцүүлэн, олон улсын стандартын дагуу бий болгож, нээлттэй хэрэглэх боломжоор хангахад анхаарах, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Үнэлгээ:

Хаягжуулалтын тухай хуулийн 1 дүгээр зүйлд тодорхойлсон хуулийн зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлах 7 зарчмаас 5 нь буюу хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5, 3.1.6, 3.1.7 дахь заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 3. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулах хуулийн зохицуулалт практикт хэрэгжиж байгаа эсэх?

Хаягжуулалтын тухай хуулийн “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулах” гэсэн 4 дүгээр зүйлд хаягжуулах үйл ажиллагааг зохицуулсан ч хаяг, хаягийн аргачлал, хаягийн мэдээллийн сан, хаягжуулах үйл ажиллагаа, хаягийн тэмдэг, тэмдэглэгээ, шуудангийн хайрцаг, хаягжуулах үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагын зохицуулалтыг тусгаж өгөөгүй байна. Тухайлбал, хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт байршлын хаягт хамаарах мэдээллүүд (нийслэл, аймаг болон сумын төв, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгонд гудамж /зам, талбай, хороолол, хотхон/-ийн нэр, дугаар, хашаа, барилга байгууламжийн нэр, эсхүл дугаар, хаалганы дугаар)-ийг заасан ч түүнийг ямар субъект хариуцан өгөх, өөрчлөх, хадгалах, уялдуулах зэрэг нь тодорхой бус байгаа юм. Түүнчлэн баг, хорооны хил, нэр өөрчлөгдөхөд энэ тухайгаа ямар байдлаар хаягийн мэдээллийн сан болон түүнийг эрхлэгч байгууллагад мэдэгдэх эсэх зохицуулалт тодорхой бус байна.

Гудамж, зам, талбай, өргөн чөлөө зэрэг хаягжуулалтын объектэд нэр өгөхөөс гадна нэрэмжит болгох, нэр өөрчлөх асуудлыг ямар субъект анхлан санаачилж хэний шийдвэрээр хэрэгжүүлэх асуудлыг зохицуулах шаардлагатай.

Харин хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэгт “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар батална.” гэж зааж, дээр дурдсан хаягийн аргачлал, хаягийн мэдээллийн сан, хаягжуулах үйл ажиллагаа, түүнд оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага зэрэг суурь зохицуулалтыг Засгийн газрын журмаар зохицуулахаар шийдвэрлэсэн байна.

Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэгт “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар батална.” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн 280 дугаар тогтоолоор “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд

хөрөнгийг хаягжуулах журам"-ыг баталсан байдаг. Уг журамд гудамжийг нэрлэх, түүний эхлэл, чиглэлийг тодорхойлох, гудамжид хамаарах үл хөдлөх эд хөрөнгийг гудамжны аль талд байгаагаас хамааруулан тэгш, сондгойгоор дугаарлахаар үндсэн аргачлалыг тодорхойлж өгсөн байна.

Уг аргачлалыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 325 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-аар нарийвчлан тогтоосон. Тухайлбал, мөн журмын:

-6.4 дэх заалтад “энэ журмын 5.2.1-д заасан үл хөдлөх эд хөрөнгө /өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн газар/-ийг дараалсан дугаарлалтын аргаар 1-ээс эхлэн дугаарлана” гэж;

-6.5 дахь заалтад “Гудамж, үл хөдлөх эд хөрөнгийн дугаарыг тухайн нутаг дэвсгэрийн суурьшлын төвөөс гадагш чиглүүлэх байдлаар эхлүүлэн дугаарлах бөгөөд дугаарлалтын эхлэлийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.” гэж;

-6.7 дахь заалтад “Өргөн чөлөө, гудамжны дагуу байрлаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийг гудамжны эхлэлээс дэс дараалан дугаарлах бөгөөд гудамжны баруун талд байрлаж байгааг тэгш тоогоор, зүүн талд байрлаж байгааг сондгой тоогоор дугаарлана” гэж;

-6.8 дахь заалтад “Гудамж тойрог хэлбэртэй тохиолдолд баруун талаас нь эхлэл тогтоож, цагийн зүүний дагуу дараалсан хувьсах аргаар үл хөдлөх хөрөнгийг дугаарлана” гэж;

-6.10 дахь заалтад “Цогцолбор барилга байгууламжийн хувьд нэгдсэн нэг дугаар олгох бөгөөд тухайн цогцолборт хамаарах барилга, байгууламж тус бүрийг нэгдсэн дугаарын ард ташуу зураас татаж тоо нэмэх замаар дугаарлана. Жишээлбэл: 102/1, 102/2 гэх мэт” гэж;

-6.13 дахь заалтад “Зуслан, гэр хорооллын хашаанд байрлах гэр, амины сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг хашааны адил дугаарлах бөгөөд тухайн хашаанд хэд хэдэн үл хөдлөх хөрөнгө байгаа тохиолдолд хашааны дугаарын ард ташуу зураас татаж тоо нэмэх замаар дугаарлана. Жишээлбэл: “102, 102/1, 102/2” гэх мэт” гэж;

-6.14 дэх заалтад “Үйлдвэрлэл, үйлчилгээний болон нийтийн орон сууцны зориулалттай барилга байгууламжийг дугаарлахдаа нэгж талбарын хаягийн дугаарын ард ташуу зураас татаж дараалсан хувьсах дугаарлалтын аргаар дугаарлана. Жишээлбэл: нэгж талбарын хаяг 100 бол барилга байгууламжийг 100/1, 100/2” гэж;

-6.15 дахь заалтад “Нийтийн зориулалттай орон сууцны байран дахь сууцыг нэг давхраас эхлэн цагийн зүүний дагуу дугаарлана” гэж;

-6.17 дахь заалтад “Хот, суурин газраас бусад орон нутагт байрлах нэгдсэн төлөвлөлт, зохион байгуулалтын дагуу бий болоогүй гудамж, зам, талбай, өмчлөх,

эзэмших, ашиглах эрх үүссэн газар, үл хөдлөх эд хөрөнгийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нэр, газар зүйн нэрийг үндэслэн зориулалтаар нь дугаарлаж, байршлын хаяг олгоно. Жишээлбэл: “Өвөрхангай аймаг, Сант сум, 2 дугаар баг, Цагаан толгой, Өвөлжөө 01” гэх мэт” гэж тус тус хаягжуулах аргачлалыг тодорхойлж өгсөн байна.

Өөрөөр хэлбэл, өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн газар буюу **нэгж талбарыг дараалсан дугаарлалтын аргаар 1-нээс эхлэн** дугаарлахаар,

-өргөн чөлөө, гудамжны дагуу байрлаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийг гудамжны эхлэлээс дэс дараалан дугаарлах бөгөөд гудамжны баруун талд байрлаж байгааг **тэгш** тоогоор, зүүн талд байрлаж байгааг **сондгой** тоогоор дугаарлахаар заажээ.

Түүнчлэн **гудамж** нь тойрог хэлбэртэй бол баруун талаас нь эхлэл тогтоож, цагийн зүүний дагуу **дараалсан хувьсах аргаар** үл хөдлөх хөрөнгийг дугаарлахаар,

-цогцолбор барилга байгууламжийн хувьд нэгдсэн нэг дугаар олгох бөгөөд дугаарын ард ташуу зураас татаж тоо нэмэх замаар дугаарлахаар,

-зуслан, гэр хорооллын хашаанд байрлах **гэр, амины сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг хашааны адил дугаарлахаар** заажээ.

Үүний зэрэгцээ, Харилцаа, холбооны зохицуулах хороо болон нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газраас шуудан, илгээмжийн хаягийн хайлт, хүргэлтийг хялбарчлах зорилгоор барилгад шуудангийн нэгдсэн кодыг өгч байна.

Харилцаа, холбооны зохицуулах хорооны цахим хуудсанд шуудангийн нэгдсэн кодыг барилга байгууламжид оноож өгдөг ба энэ нь бүсчлэлийн 5 оронтой тоо дээр 4 оронтой тооноос бүрддэг, 2022 оны байдлаар орон зайн мэдээллийн санд нийт 18 мянга гаруй барилгад шуудангийн нэгдсэн кодыг өгсөн талаар дурдсан байна (<https://www.zipcode.mn/news?p=21>).



Зураг 7. Шуудангийн нэгдсэн кодын агуулга

Дээрхээс үзэхэд хаягжуулалтын 5-7 аргачлал байна гэж үзэж болохоор байгаа ба нөхцөл шаардлагыг нарийн тодорхойлж өгөөгүй нь ойлгомжгүй байдал үүсгэж

байна. Мөн журмаар зохицуулсан дээрх хаягжуулах аргачлал нь олон улсын хаягжуулалтын аргачлал, стандартаас хэт зөрүүтэй байна.

Хуульд хаягийн талаарх суурь ойлголтыг томъёолж, түүнийг хэрхэн, ямар субъектүүд эрхлэх талаар нарийвчилж зааж өгөөгүй нь хаягжуулах үйл ажиллагаанд оролцогч талуудын дунд ойлголтын зөрүү үүсэх, уялдахгүй байх, давхардал үүсэх зэрэг нөхцөл байдлыг үүсгэсэн байна. Тухайлбал, Хаягийн мэдээллийн санг төрийн байгууллагууд өөр өөрсдийн эрхлэх асуудлын хүрээнд үүсгэж, хэрэглэж байна. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар, Харилцаа, холбооны зохицуулах хороо зэрэг байгууллага нь өөрсдийн эрхлэх асуудлын хүрээнд хаягийн мэдээллийн санг тус тус үүсгэсэн ч стандартын хувьд зөрүүтэй, харилцан уялдаа хангалтгүй хэвээр байсаар байна.

Одоогийн байдлаар зөвхөн хаягийн үйл ажиллагаанд зориулагдсан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн систем болон нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газраас хөгжүүлсэн нийслэлийн Хаягийн мэдээллийн систем гэсэн хоёр үндсэн мэдээллийн систем байна.

Хаягтай холбоотой уялдаж ажиллах шаардлагатай Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газрын кадастрын мэдээллийн систем, Хот байгуулалтын кадастрын мэдээллийн систем, Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн мэдээллийн систем, Харилцаа, холбооны зохицуулах хорооны Шуудангийн нэгдсэн кодын мэдээллийн сан, мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдээллийн систем зэрэг 5 системийг ашиглаж байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг байгуулах зорилгоор “1:1000-ны масштабтай хаягийн зураг зохиох, мэдээллийн сан бүрдүүлэх” ажлыг 2013-2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлжээ.

Тус ажлын хүрээнд 21 аймгийн 330 сумын хэмжээнд нийт 24189 гудамж, 288510 хашаа, 24351 байшин, мөн нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт 10389 гудамж, 165655 хашаа, 20543 байшин Хаягжуулалтын тухай хууль, журмын дагуу нэр өгч, дугаарлаж, хаягийн зураг зохион, мэдээллийн санг үүсгэсэн байна. Мөн дээрх ажлын хүрээнд 220 суманд 170,365 хаягийн тэмдгийг MNS 5283:2014 стандартын дагуу байршуулжээ. Улсын хэмжээнд 2023 оны байдлаар нийт 50530 гудамж, 1079711 нэгж талбар, 689888 байшин хаягийн мэдээллийн санд бүртгэгдсэн байна.

Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газраас хөгжүүлсэн нийслэлийн Хаягийн мэдээллийн систем нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системтэй хаяг авах хүсэлтийг сервисээр илгээх, авах байдлаар холбогдож байгаа ба холболтын ажил бүрэн хийгдэж дуусаагүй байна. Мөн энэхүү систем нь барилга, орон сууцны хаягийг өгөхөд түлхүү хэрэглэгдэх ба хаягийг гар аргаар өгч бүртгэдэг байна.

Хаягийн мэдээллийн нэгдсэн систем байгуулах ажлын хүрээнд дээрх санал болгосон аргачлал, дарааллын дагуу хаягийн мэдээллийн системд бүртгэлтэй 964803 хаягийн мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдээллийн сангийн бүртгэлтэй 1249248 үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн бүртгэлтэй тулгаж үзэхэд нэгж талбарын дугаараар нийт 483373 буюу 50.1%-тай таарсан байна. Энэхүү ажлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын хамтарсан баг гүйцэтгэжээ. Мөн нэгж талбарын тоот зөрүүтэй 307020 бүртгэл байгаа ба 8 буюу түүнээс доош оронтой 112646, үсэг холилдсон нэгж талбарын дугаар 324, хоосон эсвэл тусгай тэмдэгт ашигласан 117811 буюу түүнээс дээш оронтой 128465, 10 оронтой боловч нэгж талбарын дугаар таарахгүй 64407 бүртгэл байгааг тус тус илрүүлжээ. Тухайлбал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд нэгж талбарын дугаарыг 8 оронтой бүртгэсэн болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газрын кадастрын мэдээллийн системд нэгж талбарын дугаар 10 оронтой бүртгэсэн байдал.

Улсын бүртгэлийн ерөнхий газар			
Нэгж талбарын дугаар	Иргэний нэр	Регистрийн дугаар	Хаяг
60721242	Д.Должинсүрэн	ДП74122803	Говь-Алтай Есөнбулаг сум 2-р баг, Баяншанд 5 гудамж, 63 тоот
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар			
Нэгж талбарын дугаар	Иргэний нэр	Регистрийн дугаар	Хаяг
8208003725	Д.Должинсүрэн	ДП74122803	Говь-Алтай Есөнбулаг сум 2-р баг, Баяншанд 5 гудамж, 63 тоот
Нэгж талбарын дугаар зөрүүтэй нийт 307020			

Зураг 8. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон Улсын бүртгэлийн ерөнхий газарт нэгж талбарын зөрүүтэй бүртгэгдсэн байдал (Эх сурвалж: Хаягийн ажлын хэсэг)


Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд хаягийн мэдээлэлд нэгж талбарын дугаарыг дараах байдлаар зөрүүтэй бүртгэсэн байдаг байна.

UAIMAG_CITY_NAME	USOUM_DISTRICT_NAME	UADDRESS_TYPE_NAME	UPRPTY_PARCEL_ID
Өвөрхангай	Бат-Өлзий	Гэр хороолол	140301014=
Улаанбаатар	Сүхбаатар	Байр хороолол	143010/0111
Өмнөговь	Даланзадгад	Гэр хороолол	150501070=
Завхан	Сонгино	Гэр хороолол	16714434332204 а
Завхан	Цэцэн-Уул	Гэр хороолол	16720403192837~
Сэлэнгэ	Баруунбүрэн	Хөдөө	170200338=

Зураг 9. УБЕГ-т нэгж талбарын зөрүүтэй бүртгэгдсэн байдал (Эх сурвалж: Хаягийн ажлын хэсэг)

Мөн Хот байгуулалтын системд бүртгэлтэй 19308 барилгын мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэлтэй 256975 Ү-дугаартай ҮХЭХ-ийн мэдээлэлтэй тулгаж үзэхэд 2630 мэдээлэл хоорондоо таарсан байна.

Түүнчлэн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар болон нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын Хаягийн мэдээллийн сангийн барилга байрлалын хувьд зөрүүтэй байгаа байна.



Зураг 10. Барилга байрлалын хувьд зөрүүтэй бүртгэгдсэн байдал (Эх сурвалж: Хаягийн ажлын хэсэг)

Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын Хаягийн мэдээллийн сангийн болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газрын кадастрын мэдээллийн системд бүртгэлтэй барилгын мэдээллийг тулган үзэхэд нийт зөрүүтэй бүртгэгдсэн 53024 барилгын мэдээлэл байна.

Дээрх системүүдийн хувьд хоорондоо сервисээр холбогдох ба төслийн хаягийг Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системээс өгч, баталгаажилт хийгддэг байна. Системүүдийн уялдаа холбоог хангахтай холбоотой ажлууд хийгдэж байна.

Мөн журмын 5.5 дахь заалтад “Аймгийн хэмжээнд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн хэмжээнд нийслэлийн Газар зохион байгуулалтын алба энэхүү журмын 5.2.1-д заасан үл хөдлөх эд хөрөнгөд байршлын хаяг олгоно”, 5.6 дахь заалтад “Аймгийн хэмжээнд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, нийслэлийн хэмжээнд нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар энэ журмын 5.2.2, 5.2.3-т заасан үл хөдлөх эд хөрөнгөд байршлын хаяг олгоно” гэж заажээ.

Өөрөөр хэлбэл, нийслэлд нэгж талбар, аймаг, суманд хаяг олгох үйл ажиллагааг нийслэл, дүүргийн Газар зохион байгуулалтын алба, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хариуцаж байна. Харин нийслэлийн барилга, орон сууцанд хаяг олгох үйл ажиллагааг нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар хариуцан зохион байгуулж байна.

Улсын хэмжээнд Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй нийт **1,292,329** газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарын мэдээлэл байдаг бөгөөд үүнээс **644,996** эзэмших, ашиглах эрх үүссэн боловч **57.5%** буюу **370,706** нэгж талбарт хаяг олгогдоогүй байна.

Харин ГЗБГЗЗЕГ-ын мэдээллийн санд нийт өмчлөх эрх үүссэн **647,333** нэгж талбар бүртгэлтэй байдаг бол Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн санд нийт **543,292** газар өмчлөгчийн мэдээлэл бүртгэлтэй байна. Тус 2 байгууллагын мэдээллийн сангийн хаягийн мэдээллийг тулгалт хийж үзэхэд 40.8% буюу **264,056** нэгж талбарын хаяг таарч байгаа бөгөөд үлдсэн 59.2% буюу **383,277** нэгж талбарын хаягийн мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн байна.

Үнэлгээ:

Хаягжуулалтын тухай хуульд хаягжуулах аргачлал тодорхойгүй байна.

Хаягийн аргачлалыг хуулиар зааж өгөөгүйгээс зам, үл хөдлөх эд хөрөнгөд олон янзаар хаяг өгч, хаягжуулж байгаа нь нийгэмд ойлгомжгүй байдлыг бий болгож байна.

Хэдийгээр хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсэгт “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг энэ хуульд нийцүүлэн Засгийн газар батална.” гэж зааж, хаяг, хаягийн аргачлал, хаягийн мэдээллийн сан, хаягжуулах үйл ажиллагаа, хаягийн тэмдэг, тэмдэглэгээ, шуудангийн хайрцаг, түүнд оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага зэрэг суурь зохицуулалтыг тусгаж өгөлгүйгээр Засгийн газарт журмаар зохицуулахаар шийдвэрлэсэн нь хаягжуулах үйл ажиллагааг хуульд заасан зарчмын дагуу хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэсэн байна.

Иргэд, олон нийт, бизнес эрхлэгчдийн зүгээс хаяг, хаягжуулалт, түүний хүртээмж, ойлгомжтой байдал, хэрэглээнд шүүмжлэлтэй хандсан хэвээр байгаа нь Хаягжуулалтын тухай хууль нь нийгмийн харилцааг зохицуулж чадахгүй байгааг харуулж байна.

Иймээс зам, түүний төрөл, ангиллыг тодорхой болгох, нэрлэх, түүнд харьяалах нэгж талбар, барилгын дугаарлалтыг нэгдсэн нэг аргачлалаар өгөх, нөхцөл бүр дээр нарийвчлан тодорхойлсон аргачилсан заавар гаргах шаардлагатай байна.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. Хаягжуулах ажлын санхүүжилтэд бэрхшээл, хүндрэл гарч байгаа эсэх?

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэгт “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.” гэж санхүүжилтийн эх үүсвэрийг заажээ.

Хэдийгээр санхүүжилтийн эх үүсвэрийг хуульд тусгаж өгсөн нь сайшаалтай ч ямар зардал нь хаанаас гарахыг нь нарийвчлах шаардлагатай байна. Тухайлбал, хаягийн бүх мэдээллийг агуулсан хаягийн мэдээллийн сан байх практик шаардлага байгаа ба үүнийг эрхлэх санхүүжилт нь улсын төсвөөс байх шаардлагатай. Замыг нэрлэх, орон зайн мэдээллийг бүрдүүлэх, газар дээр нь тэмдэгжүүлэхтэй холбоотой зардлыг орон нутгийн төсөв, эсвэл үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого болон газрын төлбөрийн орлогоос, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн дугаарын тэмдгийг байршуулахыг өмчийн эзэн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тус тус нарийвчлан зааж өгөх шаардлагатай байна.

Мөн улсын хэмжээнд нэг удаагийн нэгдсэн арга зүйн дагуу хаягжуулах үйл ажиллагааны зардлыг ямар эх үүсвэрээр санхүүжүүлэхийг мөн тусгаж өгөх шаардлагатай байна.

Хаягжуулалтын зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа


Олон улсын судалгаанд Бүгд Найрамдах Солонгос Улс (БНУС), Шинэ Зеланд, Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Австрали зэрэг 10-аад улсуудын туршлагыг судалсан ба тэр дундаа АНУ болон Австрали улсын туршлагыг нарийвчлан судаллаа. Үүнд:

- AS/NZS 4819: Хөдөө болон хотын хаягжуулалтын стандарт;
- AS/NZS 4819: Хөдөө болон хотын хаягжуулалтын стандартын танилцуулга;
- Шинэ Зеланд улс Марлбороу хотын, Замыг нэрлэх болон хаягжуулах журам;
- Австрали улс, Баруун Австрали мужийн Хөрөнгө, гудамж хаягийн өгөгдлийн толь;
- Шинэ Зеланд улс, Хаягжуулалтын гарын авлага;
- Дэлхийн банк, Гудамж хаягжуулалт болон хотуудын менежмент;
- АНУ, Жеоржиа мужийн гудамжны хаягжуулалтын стандарт болон гарын авлага;
- Австрали улс, Нью Сөүт Вэлш мужийн Хаягийн бодлого гарын авлага.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад байрлалд суурилсан (орон зайн) мэдээллийн хэрэглээ нь нийгэм болон эдийн засгийн бүхий л түвшинд маш чухал үүрэг гүйцэтгэж байна. НҮБ, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагууд улс, орнуудын Засгийн газруудад орон зайн мэдээллийн дэд бүтцийг байгуулах нь тогтвортой хөгжлийн зорилтод хүргэх томоохон хөшүүрэг нь байх болно гэдгийг сануулсаар байна. Нийгмийн тасралтгүй хэрэгцээ, технологийн өндөр хөгжил нь орон зайн мэдээллийн хэрэглээг улам бүр нэмэгдүүлж, түүний үүрэг, ач холбогдол, цар хүрээг улам бүр нэмэгдүүлсээр байгаа юм. Тухайлбал, иргэдийн өдөр тутмын амьдралын нэг хэсэг болох харилцаа, холбоо, мэдээлэл авах, шуудан хүргэлт, хоол захиалах, хүргэх, нийтийн тээвэр, такси дуудлага, түргэн тусламж, цагдаа, гал түймэр, үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл авах, түрээслэх орон сууцаа хайх, ус, тог, газ, түрээсийн төлбөрөө төлөх, цаг агаар, онлайн худалдаа, ажил хайх зэрэг нийгмийн олон төрлийн хэрэглээнд байрлалд суурилсан мэдээллийг, тэр дундаа хаягийн мэдээллийг ашигласаар байна.

Австрали, Шинэ Зеланд болон АНУ-ын хаягжуулалтын аргачлал, түүний задаргаа


Австрали болон АНУ-ын объектод хаяг өгч буй аргачлал үндсэнд нэг зарчимтай байна. Хаягийн бүрдлийг харвал АНУ-д “1665 Harvard St NW, Washington, DC 20009, USA” буюу үл хөдлөх эд хөрөнгийн дугаар, хамаарах гудамжны нэр, замын төрөл, үндсэн чиглэл, хотын нэр, zipкод, улсын нэр бол Австрали улсад “7/253 Robinson Avenue, Cloverdale, 6105, WA, Australia” үл хөдлөх эд хөрөнгийн дугаар, хамаарах өргөн чөлөөний нэр, замын төрөл, үндсэн чиглэл, хотын нэр, zipкод, мужийн нэр, улсын нэр гэсэн мэдээллийг агуулж байна.



Зураг 11. Австрали болон АНУ-ын объектын хаягийн бүрдэл жишээ

Үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн дугаарлалт

Үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн дугаарыг тухайн үл хөдлөх эд хөрөнгө рүү хөтөлж буй хамгийн сүүлийн замын эхлэл цэгийн зүүн талд байвал сондгой, баруун талд байвал тэгш тоогоор дугаарлана.




Зураг 12 Тэгш, сондгой дугаарлалт (Эх сурвалж: AS/NZS 4819: Хөдөө болон хотын хаягжуулалтын стандарт)

Хаягийн дугаарыг үл хөдлөх эд хөрөнгийн үндсэн орц (хаалга) руу хүргэх тухайн үл хөдлөх эд хөрөнгийн харьяалагдах замын эхлэл цэгээс **алслагдсан зайн** хэмжээ, түүнийг **10-т хувааж** хураангуйлсан хэмжээгээр илэрхийлэгдэж байна. Өөрөөр хэлбэл, тухайн үл хөдлөх эд хөрөнгө рүү хүргэх орц хүртэлх зай 16,300 **метр** бол хаягийн дугаар нь 1630 болно. Энэхүү дугаарлалтын зарчим нь ихэвчлэн хөдөө, үйлдвэржилтийн бүс буюу нягтаршил харьцангуй бага хэсэгт үйлчилдэг байна.




Зураг 13 Дугаарлалт зайн хэмжээст үндэслэж буй байдал (Эх сурвалж: AS/NZS 4819: Хөдөө болон хотын хаягжуулалтын стандарт)

Хотын сууринд ойлгомжтой байлгах үүднээс замын эхлэл цэгийн зүүн талд байгаа объектуудыг 1, 3, 5, 7, баруун талынхыг 2, 4, 6, 8 гэх мэт дэс дараалсан дугаарлалтыг хэрэглэдэг байна. Өөрөөр хэлбэл, нам давхрын суурьшлын бүс дэх эзэмшлийн газруудын зам дагуу нүүрэн талын эгнээний урт ихэнх тохиолдолд 10-аас илүү метрээс ихгүй байдаг байна. Нөгөөтээгүүр, хот, суурин газарт нягтшил их байдаг тул төв замаас салсан жижиг зам бүр нэртэй байдаг нь энэхүү зарчмын дагуу дугаарлахад тохиромжтой, энгийн болгож өгдөг байна. Гэхдээ хот, суурин газрыг дайран өнгөрч буй чөлөөт хурдны зам болон өндөр хурдны замын объект нь дугаарлалт авах бол зайн хэмжээст үндэслэдэг байна.




Зураг 14. Дугаарлалт зайн хэмжээст үндэслэж буй байдал (Эх сурвалж: AS/NZS 4819: Хөдөө болон хотын хаягжуулалтын стандарт)

Мөн нам давхрын суурьшлын бүсэд (house) газар нь хуваагдсан тохиолдолд шинээр үүссэн объектод дугаарын ард үсэг өгдөг ба үсэг чиглэлийн дагуу дараалсан эрэмбэтэй байдаг байна.



Зураг 15. Газар хуваагдах, дугаарын ард үсэг авах, түүний эрэмбэ (Эх сурвалж: AS/NZS 4819: Хөдөө болон хотын хаягжуулалтын стандарт)


Газар дээрээ хэд хэдэн объектоос бүрдэх нэг том барилгын хувьд үндсэн хаягийн дугаарын урд тоо авах байдлаар хаягийн дэд дугаарлалтыг хийдэг байна.



Зураг 16. Дэд дугаарлалтын жишээ (Эх сурвалж: AS/NZS 4819: Хөдөө болон хотын хаягжуулалтын стандарт)

Хоёр болон түүнээс дээш давхар барилга, түүний доторх өмчлөл, эзэмшлийн нэгжийн дугаарлалт нь давхар, өмчлөл, эзэмшлийн нэгжийн дугаар, үндсэн хаягийн дугаараас бүрддэг байна. Тухайлбал, 1204/35 Main Street хаягийн бичиглэлийн “12” нь давхар, “04” өрөөний дагаар, 35 нь объектын үндсэн хаягийн дугаарыг илэрхийлдэг байна.

Энэ төрлийн дугаарлалтын жишээг нийтийн орон сууц, бизнесийн зориулалттай барилга, зочид буудал зэргээс харж болно. Мөн “Level, Floor”-оос бусад төрлийн давхрын төрөл нь төрлийг илэрхийлсэн кодтой байдаг байна. Жишээ нь Basement бол “B”, Ground бол “G”, Observation Deck бол “OD” зэрэг 11 төрөлтэй байна.



Зураг 17. Дэд дугаарлалтын жишээ (Эх сурвалж: AS/NZS 4819: Хөдөө болон хотын хаягжуулалтын стандарт)

Мөн үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулахад дараах зарчмыг баримталдаг байна.

Үүнд:

- Хаяг нэг байх;
- Тодорхой, логиктой байх;
- Дугаар дараалалтай байх;
- Дугаар бүхэл байх;
- Тэгш, сондгой;
- Эхлэл цэг тодорхойлсон байх.

Зам нэр, төрөл, чиглэл

Хаягт хэрэглэгдэж байгаа замын мэдээлэл нь замын чиглэл, замын нэр, замын төрөл, хавтгай гэсэн дөрвөн үндсэн мэдээллээс бүрддэг байна.



USA: 39 **N** **America** **St** **NW**, 20009, USA

AU: 7/253 **Robinson Ave**, Cloverdale, 6105, WA, Australia

Зураг 18. Замын хаягийн бүрэлдэхүүн

АНУ-ын хувьд дээрх замын дөрвөн бүрдлийг нийтлэг хэрэглэдэг бол Австрали, Шинэ Зеланд улсын хувьд замын нэр, төрлийг л хэрэглэдэг байна.

Замын чиглэл нь үндэслэл болох шугамаас хоёр дахь эрэмбийн зам руу чиглэсэн үндсэн чиглэлийг заадаг ба N, W, S, E гэсэн үсгүүдийг ашигладаг байна.

Зам бүр нэртэй байх ба дараах зарчмыг баримталдаг байна. Үүнд:

- **Avoid Duplication:** e.g., Quail Drive, Quail Lane – **Шувуут зам, Шувуут гудамж**;
- **Avoid Confusion:** easy to read, spell, and pronounce – even for children – in an emergency situation;
- **Homonyms:** Steven Lane / Stephen Lane; Disk Drive / Disc Lane – **Довчин гудамж, Дөвчин замын**;
- **Mispronounced or misspelled:** Javelina, Peony, Weimaraner – **Рэгзэднямаагиш уулын зам, ...** ;
- **Two-word names or one-word names:** Clearlake, Clear Lake, Brookhaven, Baytree – **Өргөнмөрөн, Өргөн мөрөн, ...**;
- **Not contain directional words:** North, South, East, or West;

- **Avoid Emotion:** Except where historically significant; avoid using proper names as street names (e.g., Wilma Calumet Road);
- **Promote Continuity:** A continuous street should have one name and one name only throughout its entire length, even if the street changes direction one or more times;
- **Keep Names Short:** Road names should be made up of one word, preferably of **15 characters** or fewer. *reduce data entry errors* and make the production of street signs more manageable;
- **Use Themes:** Choosing names related to a single theme (e.g., flowers, states, presidents), Also, consideration should be given to naming streets in **alphabetical order** to further aid navigation;

APPENDIX A
ROAD TYPES—AUSTRALIA
(Normative)

The road type shall be selected from those specified as suitable for open ended roads, culs-de-sac, or pedestrian only roads (see Clauses 4.3, 4.6.2, 7.2 and 8.3.2(a)).

Road type	Abbreviation	Description	Open ended	Cul-de-sac	Pedestrian only
Alley	Ally	Usually narrow roadway in cities or towns, often through city blocks or squares.	✓	✓	
Approach	App	Roadway leading to an area of community interest (e.g. public open space, commercial area, beach etc.)	✓		
Arcade	Arc	Passage having an arched roof, or any covered passageway, especially one with shops along the sides.			✓
Avenue	Av	Broad roadway, usually planted on each side with trees.	✓		
Boardwalk	Bwlk	Promenade or path, especially of wooden planks, for pedestrians and sometimes vehicles, along or overlooking a beach or waterfront.			✓
Boulevard	Bvd	Wide roadway, well paved, usually ornamented with trees and grass plots.	✓		
Break	Brk	Vehicular access on a formed or unformed surface, which was originally prepared as a firebreak.	✓		
Bypass	Bypa	Alternative roadway constructed to enable through traffic to avoid congested areas or other obstructions to movement.	✓		
Chase	Ch	Roadway leading down to a valley.	✓	✓	
Circuit	Cct	Roadway enclosing an area.	✓		
Close	Cl	Short, enclosed roadway.		✓	
Concourse	Con	Roadway that runs around a central area (e.g. public open space or commercial area).	✓		
Court	Ct	Short, enclosed roadway.		✓	
Crescent	Cr	Crescent-shaped thoroughfare, especially where both ends join the same thoroughfare.	✓		
Crest	Crst	Roadway running along the top or summit of a hill.	✓	✓	
Drive	Dr	Wide thoroughfare allowing a steady flow of traffic without many cross-streets.	✓		
Entrance	Ent	Roadway connecting other roads.	✓		
Esplanade	Esp	Level roadway, often along the seaside, lake or a river.	✓		

COPYRIGHT


ICSM – reproduced under copyright Licence 1202-c003

Мөн зам нь төрөлтэй байх ба тухайн замын төрөл түүний онцлог, шинж чанарыг илэрхийлдэг байна. Өөрөөр хэлбэл, тухайн зам руу явж буй жолооч болон зорчигч ямар онцлогтой замаар явах талаарх мэдээллийг тухайн замын төрлөөс авдаг байна.

Зураг 19 Замын төрөл (Эх сурвалж: AS/NZS 4819: Хөдөө болон хотын хаягжуулалтын стандарт)

Бидний хэрэглээнд зам, гудамж, өргөн чөлөө гэдэг үгсийг албан болон албан бус байдлаар түгээмэл хэрэглэдэг ч зам нь өөрөө төрөлтэй түүний нэг төрөл нь гудамж гэж хүлээн авч хэрэглээнд оруулах шаардлагатай байгаа юм.

Зурагт үзүүлснээр зам бол тодорхой хоёр объектыг хооронд нь холбосон замыг ойлгохоор байна. Тухайлбал, А хотоос Б хотыг холбосон зам. Гудамж гэдэгт хоёр талаараа хаус болон барилгатай хот, суурины нийтийн замыг ойлгоно гэж тодорхойлжээ. Зарим тохиолдолд зам, гудамж хоёр параллелиар байрладаггүй гэсэн зарчим мөрддөг байна. Замын төрлийг зурагт үзүүлсэн байдлаар ангилж, тодорхойлдог байна. Энэ нь эргээд объект дугаарлахад илүү хялбар болдог ба хайж олоход амар болгох үндсэн зорилготой байна.



Зураг 20 Замын төрлийн тайлбар


Хаягийн геометр утгын гео-код

Хаягийн мэдээллийн сан үүсгэх, хаягийг автоматжуулах, хаягийн мэдээллийг навигацчилалд ашиглахад хаягийн мэдээллийг гео-коджуулах шаардлага үүсдэг ба үүнийг газар зүйн мэдээллийн системийн технологийн тусламжтайгаар хийдэг байна. Өөрөөр хэлбэл, дээр аргачлалд дурдсан зам, үндсэн хаягийн дугаар болон дэд дугааруудад гео-код өгнө.

Гео-код нь зөвхөн тухайн объектын координатыг илэрхийлээд зогсохгүй дараах мэдээллийг илэрхийлдэг. Үүнд:

- Барилга руу нэвтрэх цэг;
- Барилгын төв цэг;
- Нүүрэн тал руу буусан төв шулуун;
- Аюулгүйн гарцын цэг;
- Аюулгүйн гарцын хоёр дахь цэг;
- Урд хаалганы гарц (цэг);
- Нүүрэн талын төв (цэг);

- Шуудангийн хайрцаг (цэг);
- Хөрөнгөд нэвтрэх цэг;
- Хөрөнгийн төв цэг;
- Замын чиглэл.



Зураг 21 Гео-кодын жишээ (Эх сурвалж: AS/NZS 4819: Хөдөө болон хотын хаягжуулалтын стандарт)

GEOCODE FEATURE TYPES AND DESCRIPTIONS

Geocode feature type	Description
Building access point	Point of access to the building
Building centroid	Point as centre of building and lying within its bounds (e.g. for U-shaped building).
Centre-line dropped frontage	A point on the road centre-line opposite the centre of the road frontage of an address site
Driveway frontage	Centre of driveway on address site frontage
Emergency access	Specific building or property access point for emergency services
Emergency access secondary	Specific building or property secondary access point for emergency services
Front door access	Front door of building
Frontage centre	Point on the centre of the address site frontage
Frontage centre setback	A point set back from the centre of the road frontage within an address site.
Letterbox	Place where mail is deposited.
Property access point	Access point (centre of) at the road frontage of the property
Property access point setback	A point set back from the (centre of the) access point at the road frontage of the property.
Property centroid	Point of centre of parcels making up a property and lying within its boundaries (e.g. for L-shaped property).
Unit centroid	Point at centre of unit and lying within its bounds (e.g. for U-shaped unit).
[service type] connection point	The utility connection point (e.g. box, or underground chamber). 'Service type' to be specified (e.g. water, electricity, gas, telephone)
[service type] meter	The utility meter (e.g. box, or underground chamber). 'Service type' to be specified (e.g. water, electricity, gas, telephone)

Зураг 22 Гео-кодын төрөл тайлбар (Эх сурвалж: AS/NZS 4819: Хөдөө болон хотын хаягжуулалтын стандарт)

Австрали Улсын зарим түршлага

Австрали Улсын хаягийн мэдээллийн систем нь үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, хот төлөвлөлт, онцгой байдал (цагдаа, түргэн тусламж, гал түймэр), мэдээлэл түгээлт (сонин, сэтгүүл), шуудан хүргэлт (банкны карт, бүх төрлийн гэрчилгээ, бичиг баримтууд), статистик мэдээлэл, худалдаа (онлайн худалдаа, бараа хүргэлт), үйлчилгээ (хоол хүргэлт, такси дуудлага), байгаль орчны менежмент, зураг болон атлас, замчлах систем, аялал жуулчлал, газар тариалан, ашигт малтмал зэрэг өргөн хүрээнд хэрэглэгдэж байна. Өөрөөр хэлбэл, хөгжингүй орнуудын нийгэм, эдийн засагт хаягжуулалт, хаягийн систем нь иргэнд чиглэсэн маш, олон төрлийн үүргийг гүйцэтгэж байгаа юм.



Зураг 23 Баруун Австрали мужийн хаягийн мэдээллийн сан (www0.landgate.wa.gov.au)

Австрали улсын хаягжуулалтын эрх зүйн орчин

Хаягжуулалтын үйл ажиллагаа нь Баруун Австрали мужид Газрын удирдлагын тухай хууль (1997), Баруун Австралийн газар зүйн нэрийн бодлого, стандарт (2017), Газрын мэдээллийн байгууллагын журам (2007), **Австралийн стандарт AS/NZS 4819:2011** хот болон хотоос бусад газрын хаягжуулалт болон бусад салбар эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулагдаж байна.

Хаягжуулах объект, аргачлал

Зам, байр зүйн элементүүд, амралт зугаалгын газар, засаг захиргааны нэгжийг нэрлэх болон үл хөдлөх хөрөнгөнд дугаар өгөх гэсэн үндсэн хоёр ажилбартай.

Зам, байр зүйн элементүүд, амралт зугаалгын газар, засаг захиргааны нэгжийг нэрлэхдээ газар зүйн нэрийг үндэс болгон нэрлэдэг бол үл хөдлөх хөрөнгийг дугаарлахдаа замын эхлэлээс аль талд байгаагаас нь хамааруулж тэгш, сондгойн зарчмаар дугаарладаг байна. Дугаарлахдаа амины орон сууцыг дэс дараалуулан, амины орон сууцнаас бусад барилга, байгууламжийн хувьд замын эхлэл цэгээс алслагдсан зайгаар дугаарладаг байна.

Хаягжуулахад зам, түүнийг зураглаж бүртгэх нь хамгийн чухал бөгөөд замуудыг онцлог, төрөл, шинж чанар, хэлбэрээр ангилж, гео-кодын зарчмаар зураглаж, бүртгэн (эхлэл цэг, төгсгөлийн цэг, эргэлт, мурийлт, хазайлт), нэрлэж, тухайн зам руу нэвтрэх боломжтой үл хөдлөх хөрөнгийг тэгш, сондгойн зарчмаар дугаарладаг байна (Үл хөдлөх хөрөнгийн хаягийн стандартын толь, 2018). Мөн хаягжуулахдаа холбоотой нарийвчилсан хэл, нэршил, бичвэрийн стандартыг мөрддөг байна.

Appendix 2A:

Road types suitable for use in Australia

The following table is an extract from Australian Standard AS/NZS 4819:2011 Appendix A 'Road Types – Australia'. Road types used in Western Australia shall be chosen from this list for open ended roads, cul-de-sacs or pedestrian only roads.

Road Type	Abbreviation	Description	Open ended	Cul-de-sac	Pedestrian only
Alley	Ally	Usually narrow roadway in cities or towns, often through city block or squares.	✓	✓	
Approach	App	Roadway leading to an area of community interest (e.g. public open space, commercial area, beach etc.)	✓		
Arcade	Arc	Passage having an arched roof, or any covered passageway, especially one with shops along the sides.	✓		✓
Avenue	Av	Broad roadway, usually planted on each side with trees.	✓		
Boardwalk	Bwlk	Promenade or path, especially of wooden planks, for pedestrians and sometimes vehicles, along or overlooking a beach or waterfront.			✓
Boulevard	Bvd	Wide roadway, well paved, usually ornamented with trees and grass plots.	✓		
Break	Brk	Vehicular access on a formed or unformed surface, which was originally prepared as a firebreak.	✓		
Bypass	Bypa	Alternative roadway constructed to enable through traffic to avoid congested areas or other obstructions to movement.	✓		
Chase	Ch	Roadway leading down to a valley	✓	✓	

Зураг 24. Замын аниулал (*Policies and Standards for Geographical Naming in Western Australia, 2017*)


Хаягжуулах үйл ажиллагаа, түүнд оролцогч талууд

Дээр дурдсан эрх зүйн орчны хүрээнд хаягжуулах үйл ажиллагааг Баруун Австрали мужийн Газрын мэдээллийн байгууллага буюу “Landgate” (Засгийн газрын агентлаг), түүний дэргэдэх Газар зүйн нэрийн комисс удирдан зохион байгуулдаг ба газрын асуудал эрхэлсэн сайд зам, байр зүйн элементүүд, амралт зугаалгын газар, засаг захиргааны нэгжийг батална.

Харин үл хөдлөх хөрөнгийн дугаарыг тухайн засаг захиргааны асуудал хариуцсан нэгж олгож, дээд шатны байгууллага буюу “Landgate” хянаж, баталгаажуулдаг байна. Шинээр хаяг, нэр авах, өөрчлөх хүсэлтээ тухайн шатны төрийн байгууллага (хот төлөвлөлт, иргэдийн төлөөлөгчдийн хурал), үл хөдлөх хөрөнгийн компани болон иргэд Газрын мэдээллийн байгууллагад ирүүлдэг байна. Газрын мэдээллийн байгууллагын хаягийн асуудал эрхэлсэн нэгж хүсэлтийг хүлээн авч, нягтлан, санал боловсруулан иргэд олон нийтээс санал авч, Газар зүйн нэрийн комиссын хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн саналыг Газрын асуудал эрхэлсэн сайд батална.

Газар зүйн нэрийн комисс нь 1963 онд байгуулагдсан ба Австралийн шуудан, шүүх, гал команд, цагдаа, эмнэлэг, соёл, нутгийн иргэд, уул уурхай, байгаль орчин, иргэний бүртгэл, хот төлөвлөлт, газрын харилцаа зэрэг 15 байгууллагын гишүүдээс

бүрддэг байна. Хаягжуулсан бүх объектоо Газрын мэдээллийн байгууллага нь хаягийн мэдээллийн системд оруулж, бүртгэн олон нийтэд мэдээлж, нийтийн хэрэглээнд гаргадаг байна.



Зураг 25 Баруун Австралийн Хаягжуулалтын ерөнхий схем

Хаягийн мэдээллийн сан

Хаягийн мэдээллийн сан нь газар усны мэдээллийн сан (суурь мэдээлэл) болон гудамжны хаягийн бүртгэлийн мэдээллийн сан (объектын хаягийн мэдээлэл) гэсэн хоёр үндсэн мэдээллийн сангаас бүрддэг байна. Мэдээллийн санг Газрын мэдээллийн байгууллага эрхлэх ба хаягийн суурь мэдээллээр иргэд, аж ахуй нэгжүүдэд түгээдэг байна. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгийн гудамжны хаягийн мэдээлэл, үл хөдлөх хөрөнгийн байршлын мэдээлэл, замын төвийн шугамын мэдээлэл, засаг захиргааны хилийн мэдээллээр үйлчилгээ үзүүлдэг байна (www0.landgate.wa.gov.au).

Дүгнэлт, зөвлөмж

Үүсээд буй нөхцөл байдал, үр дүнг дүгнэн үзвэл хаягжуулалттай холбоотой дараах тулгамдсан асуудал үүссэн гэж үзэж байна. Үүнд:

- Хаягийн мэдээлэл нийтэд хаалттай байна;
- Ойлголтын зөрүү байна;
- Олон улсын жишигт нийцээгүй;
- Нэгдсэн аргачлал байхгүй, тодорхой бус, нөхцөл байдал тус бүрээр нарийвчлаагүй;
- Хаягийн мэдээлэл, түүний бүрэлдэхүүн, геометр утга практик шаардлагад нийцээгүй;

- Хаягжуулах үйл ажиллагаа оролцогч талуудыг уялдааг хангаагүй, тодорхой бус;
- Оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой заагаагүй;
- Хаягийн мэдээллийн сангийн талаар зохицуулалт байхгүй;
- Хаягийн тэмдэгжүүлэлт, шуудангийн хайрцаг;
- Хаягжуулах ажлын санхүүжилтийг нарийвчлаагүй.

Хаяг нь нийгэм, эдийн засагт өргөн хэрэглэгддэг өдөр тутмын хэрэглээ бөгөөд энэхүү суурь харилцаанд нийгмийн олон талын оролцогч байдаг боловч хуульд нэр томьёотой холбоотой зүйл, заалт оруулж өгөөгүй нь хуулийг субъектив байдлаар ойлгох, тайлбарлах, хэрэглэх, нийтийн хэрэглээнд ойлгомжгүй байх, төрийн эрх бүхий байгууллагуудын хооронд ойлголтын зөрүү үүсэх, уялдаа холбоо алдагдах зэрэг нөхцөл байдлыг бий болгожээ.

Мөн Хаягжуулалтын тухай хууль нь нэгдсэн аргачлал, хаягжуулах үйл ажиллагаа, оролцогч талуудын эрх, үүрэг, уялдаа холбоо, хаягийн мэдээллийн сан, нээлттэй мэдээлэл, тэмдэг, тэмдэгжүүлэлт, шуудангийн хайрцаг зэрэг суурь асуудлуудыг зохицуулаагүй байна.

Иймд хаягжуулалтын бүрэлдэхүүн хэсэг болох дараах асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай байна. Үүнд:

- 1.Хаягийн мэдээллийг нийтэд нээлттэй болгох, хэрэглээг энгийн хялбар болгох;
- 2.Хуульд нэр томьёог нарийвчлан тусгах;
- 3.Хаягжуулалт, түүний нэгдсэн аргачлалыг тодорхой зааж, нарийвчлах, ойлголт, зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх;
- 4.Хаягжуулах үйл ажиллагаанд оролцогч талуудын уялдааг хангах зохицуулалтыг хуульд тусгах, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой зааж өгөх;
- 5.Хаягийн мэдээллийн сан, түүний мэдээлэл, бүрэлдэхүүн, түүнийг эрхлэх асуудлыг хуулиар зохицуулах;
- 6.Хаягийн тэмдэг, тэмдэгжүүлэлтийн асуудлыг хуульчлах, шуудангийн хайрцгийн хэрэглээтэй холбоотой зохицуулалтыг хуульд тусгах;
- 7.Хаягжуулах ажлын санхүүжилтийн асуудлыг нарийвчлан тусгах, санхүүгийн хөшүүрэг бий болгох.

---oOo---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

**ХАЯГЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН**

2025 он

АГУУЛГА

1. Ерөнхий зүйл
2. Шалгуур үзүүлэлтийг сонгох
3. Хамрах хүрээ
4. Олон улсын жишиг
5. Үр нөлөөний үнэлгээ
6. Үр дүн, зөвлөмж

Нэг.Ерөнхий зүйл

1.1. Хаягжуулалтын тухай хуулийг шинэчлэн найруулах тухай хуулийн төсөлд шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийн, түүний үр нөлөөг тооцож, хуулийн төслийг боловсронгуй болгоход энэхүү үнэлгээний ажлын зорилго нь оршино.

1.2. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлж, зөвлөмж боловсрууллаа.

Хоёр.Шалгуур үзүүлэлтийг сонгох

2.1.Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу дараах шалгуур үзүүлэлтийг сонгож, хуулийн тодорхой хэсгийг үнэлэв. Үүнд:

- 2.1.1.зорилгод хүрэх байдал;
- 2.1.2.практикт хэрэгжих боломж;
- 2.1.3.ойлгомжтой байдал;
- 2.1.4.хүлээн зөвшөөрөгдөх байдал;
- 2.1.5.зардал;
- 2.1.6.харилцан уялдаа.

Гурав.Хамрах хүрээ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээний хамрах хүрээ нь Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн заалтуудыг үнэлж, давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэнэ.

Дөрөв.Олон улсын жишиг

Олон улсын судалгаанд Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ), Шинэ Зеланд, Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Австрали зэрэг 10-аад улсуудын туршлагыг судалсан ба тэр дундаа АНУ болон Австрали улсын туршлагыг судаллаа. Үүнд:

- AS/NZS 4819: Хөдөө болон хотын хаягжуулалтын стандарт;
- AS/NZS 4819: Хөдөө болон хотын хаягжуулалтын стандартын танилцуулга;
- Шинэ Зеланд улс Марлбороу хотын Замыг нэрлэх болон хаягжуулах журам;
- Австрали улс, Баруун Австрали мужийн Хөрөнгө, гудамж хаягийн өгөгдлийн толь;
- Шинэ Зеланд улс, Хаягжуулалтын гарын авлага;
- Дэлхийн банк, Гудамж хаягжуулалт болон хотуудын менежмент;

- АНУ, Жеоржиа мужийн гудамжны хаягжуулалтын стандарт болон гарын авлага;
- Австрали улс, Нюв Сөүт Вэлш мужийн Хаягийн бодлого гарын авлага.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад байрлалд суурилсан (орон зайн) мэдээллийн хэрэглээ нь нийгэм болон эдийн засгийн бүхий л түвшинд маш чухал үүрэг гүйцэтгэж байна. НҮБ, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагууд улс, орнуудын Засгийн газруудад орон зайн мэдээллийн дэд бүтцийг байгуулах нь тогтвортой хөгжлийн зорилтод хүргэх томоохон хөшүүрэг нь байх болно гэдгийг сануулсаар байна. Нийгмийн тасралтгүй хэрэгцээ, технологийн өндөр хөгжил нь орон зайн мэдээллийн хэрэглээг улам бүр нэмэгдүүлж, түүний үүрэг, ач холбогдол, цар хүрээг улам бүр нэмэгдүүлсээр байгаа юм. Тухайлбал, иргэдийн өдөр тутмын амьдралын нэг хэсэг болох харилцаа, холбоо, мэдээлэл авах, шуудан хүргэлт, хоол захиалах, хүргэх, нийтийн тээвэр, такси дуудлага, түргэн тусламж, цагдаа, гал түймэр, үл хөдлөх хөрөнгийн мэдээлэл авах, түрээслэх орон сууцаа хайх, ус, тог, газ, түрээсийн төлбөрөө төлөх, цаг агаар, онлайн худалдаа, ажил хайх зэрэг нийгмийн олон төрлийн хэрэглээнд байрлалд суурилсан мэдээллийг, тэр дундаа хаягийн мэдээллийг ашигласаар байна.

Австрали болон АНУ-ын объектод хаяг өгч буй аргачлал нь үндсэндээ нэг зарчимтай байна. Хаягийн бүрдлийг харвал АНУ-д “1665 Harvard St NW, Washington, DC 20009, USA” буюу үл хөдлөх эд хөрөнгийн дугаар, хамаарах гудамжны нэр, замын төрөл, үндсэн чиглэл, хотын нэр, зип код, улсын нэр бол Австрали улсад “7/253 Robinson Avenue, Cloverdale, 6105, WA, Australia” үл хөдлөх эд хөрөнгийн дугаар, хамаарах өргөн чөлөөний нэр, замын төрөл, үндсэн чиглэл, хотын нэр, зип код, мужийн нэр, улсын нэр гэсэн мэдээллийг агуулж байна.

Хотын сууринд ойлгомжтой байлгах үүднээс замын эхлэл цэгийн зүүн талд байгаа объектуудыг 1, 3, 5, 7, баруун талынхыг 2, 4, 6, 8 гэх мэт дэс дараалсан дугаарлалтыг хэрэглэдэг байна. Өөрөөр хэлбэл, нам давхрын суурьшлын бүс дэх эзэмшлийн газруудын зам дагуу нүүрэн талын эгнээний урт ихэнх тохиолдолд 10-аас илүү метрээс ихгүй байдаг байна. Нөгөөтээгүүр, хот, суурин газарт нягтшил их байдаг тул төв замаас салсан жижиг зам бүр нэртэй байдаг нь энэхүү зарчмын дагуу дугаарлахад тохиромжтой, энгийн болгож өгдөг байна. Гэхдээ хот, суурин газрыг дайран өнгөрч буй чөлөөт хурдны зам болон өндөр хурдны замын объект нь дугаарлалт авах бол зайн хэмжээст үндэслэдэг байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн байршлын хаягийн дугаарыг тухайн үл хөдлөх эд хөрөнгө рүү хөтөлж буй хамгийн сүүлийн замын эхлэл цэгийн зүүн талд байвал сондгой, баруун талд байвал тэгш тоогоор дугаарлана.

Тав.Үр нөлөөний үнэлгээ

5.1.Зорилгод хүрэх байдал

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хаягжуулалтын тухай хуулийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон.

Тус хуулийн хаягжуулах объект нь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө гэж тодорхойлсон боловч “гудамж”, “зам”, “талбай” гэх мэт юу гэж ойлгох талаар нэр томъёоны хэсэгт тодорхойлж өгсөн нь хууль хэрэгжихэд ойлгомжтой байдал үүсгэж байна. Тухайлбал, хаягжуулалтын суурь нь замтай шууд холбогддог бөгөөд гудамж бол түүний нэг төрлөөр хэрэглэж буй практик олон улсад байна. Мөн талбай гэдэгт ногоон байгууламж, авто зогсоол, цэцэрлэгт хүрээлэн зэрэг ямар объектуудыг хамруулахаар тодорхой зааж өгсөн юм.

Тухайлбал, хуулийн 3.1.9-д “хаягжуулах” ажил нэгдсэн арга зүйгээр тодорхойлогдсон байна.

Хуулийн 12 дугаар зүйлд хаягжуулах үйл ажиллагааг зохицуулсан оролцогч талуудыг эрх, үүргийг тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал, энэ хуулийн төслийн 12 дугаар зүйлд байршлын хаягт хамаарах мэдээллүүдийг заасан ч түүнийг (нийслэл, аймаг болон сумын төв, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгонд гудамж /зам, талбай, хороолол, хотхон/-ийн нэр, дугаар, хашаа, барилга байгууламжийн нэр, эсхүл дугаар, хаалганы дугаар) ямар субъект хариуцан өгөх, өөрчлөх, хадгалах, уялдуулах зэрэг нь тодорхой тусгагдсан байна.

5.2.Практикт хэрэгжих боломж

Хуулийн 4.1.1-д “хаягжуулах ажил нэгдсэн арга зүйтэй байх” гэж тусгагдсан бөгөөд 12.3.6-т Засгийн газар шийдвэрлэхээр заасан байна.

Хуулийн 4.1.8-д “хаяг үнэн зөв, энгийн, ойлгомжтой байх” гэсэн заалт хаягжуулалтад баримтлах зарчимд тодорхой тусгагдсан байна.

Хуулийн 12.2.2-д гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журмыг тус хуульд нийцүүлэн Засгийн газар батлахаар заасан байна. Хаяг, хаягийн аргачлал, хаягийн мэдээллийн сан, хаягжуулах үйл ажиллагаа, хаягийн тэмдэг, тэмдэглэгээ, шуудангийн хайрцаг, түүнд оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага зэрэг урьдчилсан суурь зохицуулалтыг тусгаж өгөлгүйгээр Засгийн газарт эрх олгож шийдвэрлэсэн нь хаягжуулах үйл ажиллагааг хуульд заасан зарчмын дагуу хэрэгжүүлэх боломжтой байдалд хүргэсэн байна.

5.3.Ойлгомжтой байдал

Хаяг нь нийгэм, эдийн засгийн олон талт суурь харилцаа бөгөөд хуульд нэр томъёотой холбоотой зүйл, заалт оруулж өгөөгүй нь хуулийг субъектив байдлаар ойлгох, тайлбарлах, хэрэглэх, нийтийн хэрэглээнд ойлгомжгүй, төрийн эрх бүхий байгууллагуудын хооронд ойлголтын зөрүү үүсэх, уялдаа холбоо алдагдах зэрэг нөхцөл байдлыг бий болсон байна.

5.4.Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Иргэд, олон нийт, бизнес эрхлэгчдийн зүгээс хаяг, хаягжуулалт, түүний хүртээмж, ойлгомжтой байдал, хэрэглээнд шүүмжлэлтэй хандсан хэвээр байгаа нь Хаягжуулалтын тухай хууль нь нийгмийн харилцааг зохицуулахаар боловсруулагдсан.

5.5.Зардал

Хуулийн 4.8-д гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжилтийн эх үүсвэрийг заасан байна.

Хуулийн төслийн 15.1-т үйл ажиллагааны төрлийг тодорхойлон тусгасан байна. Тухайлбал, хаягийн бүх мэдээллийг агуулсан хаягийн мэдээллийн сан байх практик шаардлага байгаа ба үүнийг эрхлэх санхүүжилт нь улсын төсвөөс байх шаардлагатай. Замыг нэрлэх, орон зайн мэдээллийг бүрдүүлэх, газар дээр нь тэмдэгжүүлэхтэй холбоотой зардлыг орон нутгийн төсөв, эсвэл үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого болон газрын төлбөрийн орлогоос, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн дугаарын тэмдгийг байршуулахыг өмчийн эзэн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тус тус нарийвчлан зааж өгсөн байна.

5.6.Харилцан уялдаа
Хүснэгт 1.Харилцан уялдаа

	Шалгуур	Нийцэл	Тайлбар
1	хуулийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хаягжуулалтын тухай хуулийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тодорхойлсон ч нэр томьёо, аргачлал, мэдээллийн сан, оролцогч, талуудын эрх, үүрэг зохицуулах харилцааг зорилттойгоо нийцэхээр нэмэлтээр оруулсан байна.
2	хуулийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль болон Шуудангийн бүсчлэлийн код түүнтэй холбоотой зохицуулалтуудыг Хаягжуулалтын тухай хуульд оруулсан.
3	хуулийн тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуульд нэр томьёог тодорхойлж өгсөн. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ 3.1.4."зам" гэж тээврийн хэрэгслээр зорчиход зориулсан зурвас газрыг. Зорчих хэсэг болон түүний хажуугийн хөвөө, явган хүний зам, тусгаарлах зурвас замд хамаарна; АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬ 15.1.Авто замыг зориулалтаар нь доор дурдсанаар ажиллана. 15.1.1.олон улсын чанартай авто зам; 15.1.2.улсын чанартай авто зам; 15.1.3.орон нутгийн чанартай авто зам; 15.1.4.нийслэлийн авто зам; 15.1.5.тусгай зориулалтын авто зам; 15.1.6.аж ахуй нэгж, байгууллагын дотоод авто зам;
4	хуулийн зүйл, заалт тухайн хууль болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ 4.1.1."нэгж" гэж аймаг , сум, баг, нийслэл,дүүрэг хороог; ШУУДАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ 7.1.Шуудангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 7.1.4.шуудангийн нэгдсэн код батлах; 7.1.6.шуудангийн үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх дүрмийг батлах;
5			


Зургаа.Үр дүн, зөвлөмж

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд сонгон авсан практикт хэрэгжих боломж, хүлээн зөвшөөрөгдөх байдал, зардлын шалгуур үзүүлэлтээр хуулийн төсөлд тусгагдсан агуулгаар үр нөлөө гарна гэж үнэлсэн.

Хаягжуулалтын тухай хуулийг шинэчлэн найруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд төсөл нь практикт хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөхүйц, нэмэлт зардал гарахгүй үр өгөөжтэй байдлаар боловсруулсан байна.

Олон улсын хаягжуулалтын харьцуулалтыг судалж хаягийн бүрдэл, дугаарлалтыг тухайн үл хөдлөх эд хөрөнгө рүү хөтөлж буй хамгийн сүүлийн замын эхлэл цэгийн зүүн талд байвал сондгой, баруун талд байвал тэгш тоогоор дугаарлахаар боловсруулсан байна.

Мөн Хаягжуулалтын тухай хууль нь нэгдсэн аргачлал, хаягжуулах үйл ажиллагаа, оролцогч талуудын эрх, үүрэг, уялдаа холбоо, хаягийн мэдээллийн сан, нээлттэй мэдээлэл, тэмдэг, тэмдэгжүүлэлт зэрэг суурь асуудлуудыг бүрэн тусгаж өгсөн нь зөв боловсруулсан байна.

A dark blue vertical bar runs along the left edge of the page. A blue arrow-shaped graphic points to the right, containing the text "2025 ОН". Below this, several thin, curved lines in dark blue and light grey sweep upwards from the bottom left corner.

2025 ОН

“Хаягжуулалтын тухай хуулийн
шинэчилсэн найруулгын төсөл”-
ийг хэрэгжүүлэхтэй холбогдон
гарах зардлын тооцоо

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад тус тус гүйцэтгэнэ. Энэ нь тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулж буй хууль, тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсгэх магадлалыг урьдчилан байдлаар хийлээ.

Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл дэх зохицуулалтууд нь иргэн, хуулийн этгээдэд ачаалал болох зардал үүсэхгүй, харин төрийн байгууллагад тодорхой хэмжээгээр зардал үүсгэж байна. Иймд хуулийн төслийн зардлыг урьдчилан тооцохдоо түүнийг хэрэгжүүлэх төрийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдэд үүсэх зардлыг тоймлон гаргах, үүсэх зардал, ачааллыг бууруулах боломжтой эсэхийг судлан, боломжит хувилбарыг дэвшүүлэхийг зорьсон.

Мөн Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өмнө нь зардлын тооцоо хийгдэж байгаагүй тул энэ удаа хуулийн төсөл дэх зардал үүсгэх боломжтой зүйл, заалтыг бүхэлд нь авч үзэн зардлыг тус тус тооцсон болно.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1.Хаягжуулалтын тухай хууль” 2013 онд батлагдаж хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол улсын Засгийн газрын 2013 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 280 болон 2019 оны 325 дугаар тогтоолоор “Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам”-ыг, Стандартчилал, хэмжил зүйн газрын Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 17 ний өдрийн 1 дүгээр тогтоолоор “Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага MNS5283:2014 стандарт”-ыг тус тус баталсан.

Мөн Монгол улсын Засгийн газрын 2022 оны 181 дүгээр тогтоолоор “Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам”-д өөрчлөлт оруулж мөн Стандартчилал, хэмжил зүйн газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн С/41 дүгээр тушаалаар “Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага MNS5283:2022 стандарт”-ыг шинэчлэн баталсан юм.

Дээрх хууль, журмын дагуу хаягжуулалтын асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2020-2021 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн

системийг байгуулан Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр “Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” 180 дугаар тогтоол батлагдсан.

Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын дагуу Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг 21 аймгийн 330 сумын хэмжээнд 37,401 гудамж, 222,195 зам, 258,650 газар, усны нэр, 628,436 орц, гарцыг мэдээллийн санд хөрвүүлэн оруулж 202,159 барилга, 767,519 нэгж талбар, өвөлжөө, хаваржаа, газар тариалангийн газрын нэгж талбарт хаяг олгоод байна.

21 аймгийн 330 сумын 206 сум нь Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системээс олгосон хаягийг ашиглан газар, үл хөдлөх эд хөрөнгийн тэмдэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Харин нийслэлийн хэмжээнд болон үлдсэн 124 суманд хаягийн тэмдэгжүүлэлтийн ажил хийгдэхээр хүлээгдэж байна.

Мөн баг, хорооны Засаг даргаас эхлээд 4-5 байгууллага хаяг олгох үйл ажиллагааг эрхэлдэг байсан нь задгай болон түр хаяг олгох, давхардаж хаяг олгох, хаягийн иж бүрдэл дутуу, хаяг олгох шат дамжлага олон, хаягийн мэдээлэл нь нэгдсэн стандартгүй нь улмаас Улсын хэмжээнд хаягийн мэдээллийг ашиглахад хүндрэлтэй байсан юм.

Улсын хэмжээнд Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг байгуулах, стандартыг батлах, гудамж, зам талбайг зураглах, нэршил өгөх, газар үл хөдлөх, эд хөрөнгөнд хаяг олгох, тэмдэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн бодлого, зохион байгуулалтайгаар эрхлэн явуулах зорилгоор хууль эрх зүйн шинэчлэлтийг хийх шаардлагатай байна.

Цаашид Хаягжуулалтын тухай хуулийн төсөл батлагдсаны дараагаар дараах ажлуудыг үе шаттай зохион байгуулан ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1.Улсын хэмжээнд хаягийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах;

2.Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сантай холбох, хэрэглээнд нэвтрүүлж, газар болон үл хөдлөх, эд хөрөнгийн хаягийн мэдээллийг шинэчлэн зохион байгуулах;

3.Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн газрын бүртгэлийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд холбох, газар болон үл хөдлөх, эд хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулах;

4.Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд Улс болон Орон нутгийн чанартай авто замуудын тоон мэдээллийг холбож, замчлах системийн суурь өгөгдөл мэдээллийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

5.Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системд барилгын мэдээллүүдийг холбож байнга харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэн бүх барилгад хаяг олгох ажлыг зохион байгуулах;

6.Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг ХУР системээр дамжуулан төрийн байгууллагуудын мэдээллийн сантай холбох, хэрэглээнд гаргах, төр болон хувийн хэвшил, иргэн хаягийн мэдээллийг өдөр тутамдаа ашиглах боломжийг бүрдүүлэх, дээрх ажилтай холбогдуулан шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, системийн хөгжүүлэлтийг хийх;

7.Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг ашиглан хаяг олгох үйл ажиллагааг орон нутгийн хэмжээндээ хэрэгжүүлэн ажиллах, тус системийн дагуу олгогдсон хаягийн мэдээллийг газар болон үл хөдлөх, эд хөрөнгөнд байршуулан тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлуудыг тус тус хийж гүйцэтгэх юм.

Иймд Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгад туссаны дагуу гудамж, зам, талбайг тэмдэгжүүлэх, газар, үл хөдлөх, эд хөрөнгийг хаягжуулах, хаягийн мэдээллийг бичиг баримтад солих болон тэмдэг, самбарыг байршуулахад шаардагдах санхүүжилтийн асуудлыг нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байна.

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДАЛ

Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд иргэний газар болон, үл хөдлөх, эд хөрөнгийг хаягжуулалтын дагуу тэмдэгжүүлэх тохиолдолд төр нэг удаа шинэчлэн хийхээр үүрэг хүлээнэ.

Захиргааны зардлын тооцоог дэлгэрэнгүй байдлаар судалгааны ажлын "Хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг стандарт зардлын загвараар тооцох нь" хэсгээс үзэж танилцана уу.

2015-2024 оны Газрын нэгдмэл сангийн улсын нэгдсэн тайлангаас статистик, тоо мэдээний дундаж хэмжээгээр тооцоолоход одоо хүчин төгөлдөр газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч 1,130,212 иргэн, хуулийн этгээдийн газрыг шинээр хаягжуулахад 281,531,189 төгрөг шаардлагатай болно.

Төрийн захиргааны байгууллагад үүсэх зардлын дийлэнхийг хаягжуулалттай холбоотой орон зайн давхаргыг зураглах, тоног төхөөрөмжийг сайжруулах мэдээллийн

санг хөгжүүлэхэд гарах зардал эзэлж байгаа бол аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн нутгийн захиргааны байгууллагын ажлын ачааллыг бууруулах үүднээс хүний нөөцийг нэмэгдүүлэхтэй холбоотой тодорхой зардал үүсэх магадлалтай.

Иймд хуулийн төслийг хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө өгөгдөл мэдээллийг боловсруулах, байгууллагуудын өгөгдөл мэдээллийг нэгтгэх, засварлах мэдээллийн системийг байгуулах шаардлагатай байгаа тул хуулийн төслийг батлах тохиолдолд дээрх ажлуудыг хийж гүйцэтгэхтэй холбоотой судалгаанд дурдсан санхүүжилт болон техникийн нөхцөлийг хангахтай холбоотой үүсэх зардлыг төр хүлээх юм.

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын хүрээнд тус бүрийн мэдээлэл цуглуулан, стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэн дараах тооцооллыг хийлээ.

1.1. Иргэн, хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох

Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд иргэн, хуулийн этгээдийн газар болон үл хөдлөх, эд хөрөнгийн хаягийг тэмдэгжүүлэхээр төр үүрэг хүлээлгэсэн дараах зохицуулалт байна.

Хүснэгт 1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалт

Зүйл заалт	Хуулийн төсөл дэх холбогдох зохицуулалт
15 дугаар зүйл. Хаягжуулалтын үйл ажиллагааны санхүүжилт	15.1.Улсын болон орон нутгийн төсвөөс дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ:
	15.2.2. нэгдсэн байдлаар хаягжуулсны дараа шинээр өмчлөх, эзэмших, ашиглах эрх үүссэн тохиолдолд хаягжуулахтай холбоотой зардал.

1.2. Үндсэн зардлын тооцоо дараах байдалтай байна. /Хүснэгт-2/

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ \төг\	Нийт зардал \төг\	Хөрөнгө оруулалтын хэлбэр	Тайлбар
1	Улсын хэмжээнд тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах					
1.1	21 аймаг, 330 сумын хэмжээнд тэмдэгжүүлэх ажлыг хийх	362,000	552,500	200,005,000,000	Улсын болон орон нутгийн төсөв	

1.2	Нийслэлийн хэмжээнд тэмдэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэх	1,200,000	552,500	663,000,000,000		Улсын хэмжээнд нийт гудамжны 13.4 хувьд хууль, журмын дагуу стандарт хаягийн тэмдэг байршуулсан.
1.3	Шинээр өргөн чөлөө гудамжны нэрийн тэмдэг байрлуулах	304	250000*2	152,000,000		
1.4	Шинээр гудамжны нэр, гэр хорооллын гудамжны тэмдэг байрлуулах	50231	50000	2,511,550,000		
2	Иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн гэрчилгээний хаяг солих					
2.1	Үл хөдлөх, эд хөрөнгийн гэрчилгээ солих	695,602	20,000	13,912,040,000	Улсын болон орон нутгийн төсөв	Улсын бүртгэлийн ерөнхий газартай дундын мэдээллийн сангаар хаягийн мэдээллийг солилцоно. Иргэний үнэмлэхний оршин суугаа хаягийн өөрчлөлтийг өгөгдлийн санд хийх тул гэрчилгээ солих, бусад зардал гарахгүй.
2.2	Өмчлөх газрын гэрчилгээ солих	539,357	20,000	10,787,140,000		
2.3	Хуулийн этгээдийн гэрчилгээ солих	226,074	88,500	20,007,549,000		
3	Хаягийн мэдээллийн системийн өгөгдлийн санг байршуулах					
3.1	Үндэсний дата төвд нөөц сервер	1 сервер 1 сторэйж	60.000.000 54.000.000	114,000,000	Улсын төсөв	Системийн аюулгүй найдвартай ажиллагааг хангах үүднээс Үндэсний дата төв хаягийн

						мэдээллийн сангийн нөөц серверийг байршуулах шаардлагатай
3.2	ГЗБГЗЗГ-ын байгууллагын дата төвд нэмэлт сервер	1 сервер 1 сторэйж	60.000.000 54.000.000	114,000,000	Улсын төсөв	Байгууллагын дата төвийн ачааллыг багасгах системийн найдвартай тасралтгүй ажиллагааг хангаж ажиллах
	НИЙТ ДҮН			910,603,279,000		

1.2. Хэрэв үл хөдлөх, эд хөрөнгийн гэрчилгээ, өмчлөх газрын гэрчилгээ, хуулийн этгээдийн гэрчилгээг солихгүйгээр холбогдох нууцлал бүхий тэмдэгт байршуулах эсвэл тухай бүр харилцаанд ороход нь солин гэж үзвэл дараах зардлын тооцоо гарж байна. /Хүснэгт-3/

Д\д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ \төг\	Нийт зардал \төг\	Хөрөнгө оруулалтын хэлбэр	Тайлбар
1	Улсын хэмжээнд тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах					
1.1	21 аймаг, 330 сумын хэмжээнд тэмдэгжүүлэх ажлыг хийх	362,000	552,500	200,005,000,000	Улсын болон орон нутгийн төсөв	
1.2	Нийслэлийн хэмжээнд тэмдэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэх	1,200,000	552,500	663,000,000,000		
1.3	Шинээр өргөн чөлөө гудамжны нэрийн тэмдэг байрлуулах	304	250000*2	152,000,000		Улсын хэмжээнд нийт гудамжны 13.4 хувьд хууль, журмын дагуу стандарт хаягийн тэмдэг байршуулсан.
1.4	Шинээр гудамжны нэр, гэр хорооллын гудамжны тэмдэг байрлуулах	50231	50000	2,511,550,000		
3	Хаягийн мэдээллийн системийн өгөгдлийн санг байршуулах					

3.1	Үндэсний дата төвд нөөц сервер	1 сервер 1 сторэйж	60.000.000 54.000.000	114,000,000	Улсын төсөв	Системийн аюулгүй найдвартай ажиллагааг хангах үүднээс Үндэсний дата төв хаягийн мэдээллийн сангийн нөөц серверийг байршуулах шаардлагатай
3.2	ГЗБГЗЗГ-ын байгууллагын дата төвд нэмэлт сервер	1 сервер 1 сторэйж	60.000.000 54.000.000	114,000,000	Улсын төсөв	Байгууллагын дата төвийн ачааллыг багасгах системийн найдвартай тасралтгүй ажиллагааг хангаж ажиллах
	НИЙТ ДҮН			865,896,550,000		

Улсын бүртгэлийн ерөнхий газартай дундын мэдээллийн сангаар хаягийн мэдээллийг солилцоно. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний өөрчлөлт хэсэгт хаягийн өөрчлөлтийг хийх тул гэрчилгээ солих, бусад зардал гарахгүй.

ХУВИЛБАРЫГ НЯГТЛАХ АЖЛЫГ ДАРААХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ДАГУУ ГҮЙЦЭТГЭНЭ:

- 1.Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:
- 2.Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:
- 3.Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх:
- 4.Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх:
- 5.Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх:

✓ **Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх:** Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас Улсын хэмжээнд хаягийн нэгдсэн системийг эхний байдлаар хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна. Мөн дээрх ажлын хүрээнд олон улсын туршлага судлан 2024 оны 03 дугаар сард Бүгд Найрамдах Солонгос Улсын Дотоод хэрэг, аюулгүй байдлын яам, Газар геоматик (LX) корпорацтай хамтран ажилласан болно. Түүнчлэн хоёр улсын холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмуудыг үндэслэн хаягжуулалтын нэгдсэн системийг шинэчилж байгуулах талаар мэдлэг, туршлага хуваалцах, хамтран ажиллах зорилгоор 2024 оны 05

дугаар сарын 24-ний өдөр Сөүл хотод Бүгд Найрамдах Солонгос Улсын Дотоод хэрэг, аюулгүй байдлын яам болон Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах ажил зохион байгуулагдаж, Монгол улсын хэмжээнд 2026 онд хаягжуулалтын нэгдсэн системийг байгуулах төсөл хэрэгжихээр болсон юм. Дээрх ажлуудыг илүү боловсронгуй болгох бүртгэлийн ажилтны ачааллыг багасгах боломж байгаа нь харагдаж байна.

✓ **Хамрагдах иргэн, хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:** Энэ тохиолдолд хамрагдах иргэн, хуулийн этгээдийн тоог багасгах боломжгүй бөгөөд Нийгэм, эдийн засгийн хөгжлийн явцад шинэ тутам үүсэж байгаа газартай холбоотой олон талт харилцааг зохицуулах нь зайлшгүй юм.

✓ **Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх:** Хуулийн төсөлд зааснаар иргэн, хуулийн этгээдийн газар, үл хөдлөх, эд хөрөнгийг хаягжуулахад хуулийн дагуу хэрэгжүүлж буй үйл ажиллагааны давтамжийг бууруулах боломжгүй.

✓ **Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх:** Хуулийн төсөлд зааснаар иргэн, хуулийн этгээд газар болон үл хөдлөх, эд хөрөнгийн бүртгэлийг нэгдсэн стандартад оруулах, хаягжуулах, орон зайн өгөгдөл мэдээллийг боловсруулах болон одоогийн 2 хэмжээст бүртгэлийг 3 хэмжээст бүртгэлд шилжүүлэх суурь алхмыг хийх тул мэдээллийн агуулгыг багасгах шаардлагагүй.

✓ **Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх:** Хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдийн газар, үл хөдлөх, эд хөрөнгийг хаягжуулах асуудлын хүрээнд холбогдох шаардлагыг тогтоосон зохицуулалт орсон тул энэ тохиолдолд агуулгаас татгалзах асуудал хөндөгдөхгүй.

3.4.Үр дүн, санал

Хуулийн батлагдсанаар хаягийн мэдээллийг удирдах дэвшилтэд системийг байгуулах, Гудамж, зам, талбай, газар, үл хөдлөх эд хөрөнгийг үнэн бодит, алдаагүй хаягжуулуулах, замчлалын үйлчилгээнд тусгайлан зориулсан нарийвчилсан замын сүлжээний зурагтай болох, газар, үл хөдлөх, эд хөрөнгийг хаягжуулах, тэмдэгжүүлэх, Төр, хувийн хэвшлийн төрөл бүрийн үйлчилгээ болох түргэн тусламж, онцгой байдлын тусламж үйлчилгээ, ачаа тээвэр хүргэлт, бизнесийн салбарын байршил, маркетинг борлуулалт хийх үйл ажиллагаа хялбар, шуурхай болгоход шаардлагатай орон зайн өгөгдлийг бүрдүүлэх боломжтой болох юм.

Судалгааны дүнгээс харахад Хаягжуулалтын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хийсэн зардлын тооцооны үр дүнг нэгтгэн үзэхэд тус хуулийн төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд урьдчилсан байдлаар **865,896,550,000** төгрөгийн зардал нэг удаа гарах магадлалтай байна.

"Хаягжуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл"-ийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай “17.7” дахь хэсгийг нэмсүгэй.

“17.7.Авто замын тухай хуулийн 17.2, 17.3, 17.4-т заасан авто зам эзэмшигч нь авто замын мэдээллийг шинээр байгуулах болон өөрчлөхдөө газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ.”

2 дугаар зүйл. Авто замын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын чиглэл, чиглэлийн нэр, дугаарыг авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэл, орон нутгийн чанартай авто замын чиглэл, чиглэлийн нэр, дугаарыг тухайн шатны Засаг дарга авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн тогтооно” гэснийг “нийслэл, орон нутгийн чанартай авто замын чиглэл, чиглэлийн нэр, дугаарыг тухайн шатны Засаг дарга авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн тогтооно” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хаягжуулалтын тухай хууль (шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 2 дахь хэсгийг нэмсүгэй.

“2.Улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангуулах зориулалттай тусгай объектын хаягийн бүрдэл мэдээллийг хаягийн зурагт тусгах, нийтэд түгээсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хаягжуулалтын тухай хууль (шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай “6.3.8” дахь заалт нэмсүгэй:

“6.3.8.Үл хөдлөх, эд хөрөнгийн дугаар.”

2 дугаар зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2 дахь заалтын “хаягийн сан” гэснийг “хаягийн нэрийн сан” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хаягжуулалтын тухай хууль (шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХАЯГЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр баталсан Хаягжуулалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хаягжуулалтын тухай хууль (шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ